



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ
СУМЫН ХОТГОРЫН НҮҮРСНИЙ УУРХАЙГААС
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНТЭС СУМЫН
НАРИЙНСУХАЙТЫН НҮҮРС ТЭЭВРИЙН ЗАМ
ХҮРТЭЛХ 288.45 КМ УРТ ХАТУУ ХУЧИЛТТАЙ
АВТО ЗАМЫН ТӨСӨЛ**

Агуулга

Агуулга	2
1. Төслийн товч танилцуулга	5
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	9
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	14
4. Төслийн үе шатны хэрэгжилтийн талаарх товч танилцуулга	17
4.1 Гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээний төлөв	18
4.2 Төслийн авто замын үндсэн өгөгдлүүд.....	21
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	24
5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр түр зам болон карьераас материал олборлолтын үеийн зам усалгаа.	26
5.2 Түр замын батлагдсан маршрут	30
5.3 Түр замын тэмдэг тэмдэглэгээ	34
5.4 Түр замын дагуу тээврийн хэрэгслийн хурдны хязгаарлалт хийх, хурдны хязгаар тогтоосон дотоод журам боловсруулах.....	45
5.5 Замын засвар арчилгааны хувиарыг гаргаж, замыг засаж нягтаршуулах	45
5.6 Техникийн үзлэг.....	47
5.7 Хөрсөн бүрхэвч газрын гадаргад үзүүлэх нөлөөллийг бууруулах	49
5.8 Хөрсний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	51
5.8.1 Шимт хөрсний хадгалалт, хэлбэржүүлэлт ба тэмдэг тэмдэглэгээ	51
5.8.2 Авто замын бүтээн байгуулалтын үед машин техникээс шатах тослох материал асгарах тохиолдолд авах арга хэмжээ	53
5.8.3 Усан орчин төлөвлөгөөний хэрэгжилт	55
Ус ашиглах дүгнэлт болон гэрээ.....	56
Усыг гэрээний дагуу ашиглаж , хяналт тавьсан байдал	58
Тоолуур суурилуулалт ба баталгаажуулалт.....	59
Усныг ариг гамтай хэрэглэх ашиглах.....	60
Усны шинжилгээ.....	61
5.9 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.....	62
Ургамал болон амьтны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	63
5.10 Амьтны аймаг үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.....	66
Биотехникийн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	67
Зэрлэг ан амьтны талаарх сургалт	67
5.11 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт	69

Орчны тохижилт ажил-1.....	69
5.12 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	71
5.13 Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	76
5.14 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	77
5.15 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	83
5.16 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	86
5.17 Агаарын чанарын хяналт шинжилгээ	88
Хүхэрлэг хийн агууламж (SO ₂)	90
Азотын давхар исэл (NO ₂).....	90
Нийт тоос /TSP/.....	91
Дуу чимээ.....	92
Усан орчны хяналт шинжилгээ	93
Хөрсний мониторинг	97
5.18 Хөрсний мониторинг цэгүүдийн гадаргын өнөөгийн төлөв байдал.....	99
Хөрсний агро-хими, физик шинж чанар	99
Хөрсний урвалын орчин (pH)	99
Хөрсний карбонатжилт.....	100
Хөрсний механик бүрэлдэхүүн	100
Хөрсний нянгийн бохирдол	101
Хөрсний хүнд металл.....	101
Ургамал мониторинг шинжилгээ.....	104
Төслийн талбайн ургамалжлын төлөв байдал	105
Ургамлын мониторингийн товч дүгнэлт	108
Амьтны аймгийн хяналт мониторингийн	109
Замын дагуу таарах ховор хөхтөн амьтад, тархац, байршил	109
5.19 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	114
5.20 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	116
6. ХАВСРАЛТУУД	Error! Bookmark not defined.



БҮЛЭГ 1.

**ТӨСЛИЙН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсөл хэрэгжүүлэгч: “Сэкер ресорсус” ХХК, улсын бүртгэлийн дугаар:9019097451, регистрийн дугаар: 2862468

Төслийн байршил: Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хүнд даацын тээврийн хэрэгслийн тусгай зориулалтын авто зам

Монгол улсад бүртгэлтэй, улсын бүртгэлийн 2862468 регистрийн дугаар бүхий “Сэкер Ресорсус Монголиа” ХХК нь 2024 оны 08-р сарын 07-нд ЗТЯ-тай “Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Хотгорын уурхайгаас Нарийнсухайт -Шивээхүрэн чиглэлийн авто замд холбох тусгай зориулалтын авто зам”-ыг өөрийн хөрөнгөөр барьж ашиглахаар гэрээ байгуулсан.


Дээрх гэрээний үндсэн дээр “Сэкер Ресорсус Монголиа” ХХК нь “Баянхонгор аймгийн Шинэжинст сумын “Хотгорын уурхайгаас Нарийнсухайт - Шивээхүрэн чиглэлийн нүүрс тээврийн замтай холбох тусгай зориулалтын авто зам”-ын урьд нь боловсруулсан Техник эдийн засгийн үндэслэл болон нарийвчилсан зураг төслийг “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016 стандартад нийцүүлэн шинэчлэх ажлыг “Пивотал Инфра Эм Жи Эл” ХХК ба “Ай Си Ти Сайн Консалтинг” ХХК-ийн түншлэлээр 2024 онд хийлгэсэн байна.

“Баянхонгор аймгийн Шинэжинст сумын “Хотгорын уурхайгаас Нарийнсухайт - Шивээхүрэн чиглэлийн нүүрс тээврийн замтай холбох тусгай зориулалтын авто зам”-ыг барьж байгуулах ажилд техник технологийн байнгын хяналтыг хэрэгжүүлэх Бие даасан Инженерийн Зөвлөх Үйлчилгээг үзүүлэхээр 2024 оны 9 сарын 3-ны өдөр “Пивотал Инфра Эм Жи Эл” ХХК ба “Ай Си Ти Сайн Консалтинг” ХХК-ий түншлэл нь уг төслийн захиалагч болох “Сэкер Ресорсус Монголиа” ХХК-тай 202402011117 тоот Зөвлөхийн Гэрээ байгуулж гарын үсэг зурж баталгаажуулсан билээ.

Сэкер Ресорсус Монголиа ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Хотгор чулуун нүүрсний уурхайн бүтээгдэхүүнээ Шивээхүрэн боомтоор экспортлох зорилгоор Хотгор чулуун нүүрсний уурхайгаас Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэл нийт 288.45 км авто замыг барихаар төлөвлөж байна. Тус 288.45 км хүнд даацын тээврийн хэрэгслийн тусгай зориулалтын авто зам нь дараах чигийн тэнхлэгийн координатын дагуу баригдана. Үүнд:

Эхлэх цэг: Баянхонгор аймгийн Шинэжинст сумын 2-р багийн нутагт дэвсгэрт орших Сэкер Ресорсус Монголиа ХХК -ийн Хотгор чулуун нүүрсний уурхайн (44° 34' 5.15" N; 99° 16' 36.51" E) талбайгаас эхэлнэ.

Төгсөх цэг: Өмнөговь аймгийн Гурван тэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам (42° 57' 21.07" N; 101° 16' 27.47" E) –тай холбогдоно.



Зураг 1 Авто замын байршлын зураг

Төслийн хүчин чадал: Замын трасс нь Монгол орны баруун урд хэсэгт автозамын цаг уурын ИВ, ША, ШВ бүсэд хамаарах ба жилд 12 сая тн нүүрс тээвэрлэх хүчин чадалтай баригдах бөгөөд өдрийн дундаж хөдөлгөөний эрчим 1,298-3,815 ш бага болон хүнд даацын авто машин өнгөрөхөөр төлөвлөсөн.

Ажиллах хүч: Төслийн хугацаанд буюу зам барилгын үед нийт 809 хүн ажиллана. Замын барилгын үндсэн үзүүлэлт: Автозам нь “Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016” нормын дагуу “Хүнд даацын тээврийн хэрэгслийн тусгай зориулалтын автозамын төсөллөлт”-ийн шаардлагыг хангасан 2 талдаа 4м өргөн хайрган хөвөө, 8 м-ийн өргөн зорчих хэсэгтэй, далангийн өргөн нь 16м, 2 эгнээ замыг барина.

Ус зайлуулах байгууламжийн асуудлыг шийдэж шаардлагатай газруудад хоолой, болон ус давуулах даланг төлөвлөсөн. Төслийн ТЭЗҮ-д тусгаснаар ус зайлуулах байгууламжийн хувьд 1х1 м хэмжээтэй дугуй хоолой – 439 ш, 1 : 1 : 1 м хэмжээтэй дөрвөлжин хоолой – 30 ш, 2:1:1 м

хэмжээтэй дөрвөлжин хоолой – 104 ш, 3:1:1 м хэмжээтэй дөрвөлжин хоолой – 26 ш, нийт дугуй болон дөрвөлжин хоолой 599 ш, 10,000 м урт ус давуулах далан 109 ш, нийт 708 ш ус зайлуулах байгууламж барихаар төлөвлөсөн байна. Эдгээр ус зайлуулах байгууламжууд нь 6 тэнхлэгтэй 100 хүртэл тн-ын даацтай хүнд даацын ачаатай машинуудыг даах чадвартай байхаар төлөвлөгдсөн. Уулархаг болон нугачаатай газар, ухмалтай хэсгүүдэд 199, 835 м трапец хэлбэрийн шуудуунуудтай байна.

Автозамын хучилтад асфальт бетон хучилт-50мм, цементээр бэхжүүлсэн буталсан чулуун суурь-200 мм, цементээр бэхжүүлсэн байгалийн хөрсөн суурь-200мм, хөлдөлтөөс хамгаалах дэд суурийн үе - 200 мм, ба далангийн үеүд нь 0.075 мм-ээс жижиг хэмжээтэй материалын агуулга нь 10%, дор хаяж 8%-ийн CBR-тэй байна.

Дэд бүтэц:

Цахилгаан хангамж – Зам барилгын ажлын үеийн цахилгааны хэрэглээг 50, 100, 200, 300, 350, 500kW-хүчин чадалтай нийт 74 дизель генератораар хангана.

Ус хангамж – Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт байрлах өөрийн 8 худгаас болон Гурвантэс сумын нутагт байрлах 2 худгаас гэрээгээр зам барилгын ажилд шаардлагатай усыг хангана.

Түүхий эд – Авто замын барилгын ажилд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах сумдын засаг дарга нарын захирамжийн дагуу шороон материалын 5, элсний материалын 2, элс, шороо, чулууны 8 ордуудыг ашиглана.

Тоног төхөөрөмж – Гинжит трактор, дугуйт трактор, бульдозер, грейдер, дугуйт ачигч, экскаватор, хүнд даацын ачааны машин зэргийг авто замын барилгын ажилд ашиглана.



БҮЛЭГ 2.

ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүй. Говь-Алтайн уулт тогтолцооны гарал үүслийн хөгжил нь шинэхэн тектоникийн уул үүсэх хөдөлгөөнтэй холбоотой бөгөөд энэ асуудлаар судлаачдын санал нэлээд хол зөрүүтэй бас маргаантай байдаг боловч ихэнх нь Говь-Алтайн уулт өргөгдлийг плиоцен, плейстоцены заагт болж өнгөрсөн гэдэг ба тогтцын хувьд хагарлуудаар хэсэг бүлэг блокуудад хуваагдаж шилжин хөдлөхийн зэрэгцээгээр янз бүрийн цаг үеүдэд эргэж хөрвөж, атирч, эвдэрч өөрчлөгдсөн нэн ээдрээтэй, нийлмэл бүтэцтэй гэж үздэг. Говь-Алтайн нуруу, түүний системд багтаж буй өмнөд хэсгийн зэрэгцсэн, цуварсан хэсэг бүлэг уулс, тэдгээрийг өөр хооронд нь заагласан өргөн уудам бэл хөндийг шинээр тавигдах автозам дамжин өнгөрөхөөр төлөвлөгджээ.

Цаг уур, уур амьсгал. Төслийн талбай орчмын газар нутаг нь эх газрын эрс тэс, хахир ширүүн, хуурай-дулаан-хүйтэвтэр хосолсон уур амьсгалтай бөгөөд өвөл нь хүйтэвтэр, зун нь аагим халуун, хавар намар нь салхитай дулаан байдаг. Гурвантэс сумын нутагт агаарын жилийн дундаж температур 4.0°C - 4.60°C , агаарын үнэмлэхүй температур жилийн бүх сард эерэг (тухайлбал, өвлийн 1-р сард $+7.80^{\circ}\text{C}$) байдаг. Түүнчлэн Гурвантэс суманд салхины жилийн дундаж хурд 3.6м/с , намар болон хавар $4\text{-}6\text{м/с}$, өвлийн саруудад $3\text{-}4.7\text{м/с}$, бусад саруудад $2\text{-}4\text{м/с}$ байна. Тус нутаг нь салхины хагалбар урсгалын дагуу баруун хойдоос зүүн өмнө рүү салхилах үндсэн горимтой бөгөөд ихэвчлэн “уул хөндийн” салхи зонхилно.

Агаарын чанар. Замын трасс нь нэлээд өргөн нутаг дэвсгэрийг хамарч байгаа тул трассын дагуу нийт 12 цэгийг сонгон агаарын чанарын хэмжилтийг гүйцэтгэсэн байна. Шинжилгээний дүнгээр агаар дахь хүхэрлэг хийн агууламж $0.005\text{-}0.010\text{ мг/м}^3$, азотын давхар ислийн агууламж $0.009\text{-}0.024$ хii Сэкер Ресорсус Монголиа ХХК-ийн Хотгор чулуун нүүрсний уурхайгаас Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км авто замын төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан (Нэмэлт тодотгол) - 2024 он мг/м^3 , нийт тоосны агууламж $0.016\text{-}0.024\text{ мг/м}^3$ байсан ба Монгол улсын агаарын чанарын стандарт MNS4585:2016-д заасан нэг удаагийн зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаараас бага түвшинд байна. Хээрийн судалгааны хугацаанд хүчтэй шороон шуурга зэрэг байгалийн онц үзэгдэл ажиглагдаагүй ба замын трассын дагуу агаар дахь нийт тоосны агууламж ерөнхийдөө жигд бага байна. Хүхэрлэг хий, азотын давхар ислийн хувьд ерөнхийдөө мөн жигд бага илэрцтэй байгаа нь төслийн талбайн хэмжээнд эдгээр бохирдуулах бодисуудыг ялгаруулах бусад эх үүсвэр одоогоор байхгүй байгааг харуулж байна. Төслийн талбайн ихэнх нутаг дэвсгэр чимээ аниргүй бөгөөд энэ бүс нутаг дахь цөөн тооны малчид, зэрлэг болон ахуйн мал амьтдаас өөр дуу чимээ үүсгэх эх үүсвэр байхгүй. Хэмжилтийн үр дүнгээс харахад дуу чимээний түвшин нь хэвийн бөгөөд зөвшөөрөгдөх хэмжээний хязгаарт байна. Өдрийн цагаар шувууд, шавжийн идэвхжилттэй холбоотойгоор

дуу чимээний түвшин нэмэгддэг. Судалгааны үеэр дуу шуугианы хамгийн их түвшин 38 дБ(А)-с хэтрээгүй байна.

Хөрсөн бүрхэвч. Судалгаанд замын трассаас хоёр тийш 1.5 км буюу нийтдээ 3 км өргөн зурвасыг хамруулсан бөгөөд талбайн хүрээнд аараг толгод бүхий гадарга нь гуу жалгын хэрчигдэл ихтэй нам уулс болон тэдгээрийн хоорондох өргөн нарийн хуурай сайрууд, тэгшивтэр хөндий болон талархаг гадарга, жижиг дов довцог, шалархуу хотгор хонхор, элсэрхэг дов довцог зэрэг гадаргын олон янзын хэлбэрийг хамарч д.т.д 886-2315 м өндөрт байрлана. Судалгаанд хамрагдсан талбайд Монгол орны хөрсний ангиллаар Борсаарал, Бор, Цайвархүрэн, Сайрын хөрсний дэд хэв шинжид багтах чулуурхаг, нимгэн, сайргархаг, элсэн, хужирлаг төрлийн хөрснүүд дангаараа болон бүрдэл байдлаар тархсан байна. Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин багаас маш бага, шимт үе давхарга нь нимгэн (0-30 см), хэврэг өрмөнцөр, жижиг бөөмөрхөг болон үйрмэг бүтэцтэй, механик нөлөөлөлд тэсвэргүй, байгалийн аясаараа нөхөн сэргэх чадамж маш сул байдаг онцлогтой. Мөн маш их чулуурхаг, том ширхэгтэй элсний агууламж өндөртэй байна. Хөрсний үе давхарга нь ихэвчлэн ВВС-С гэсэн дараалалтай, хөрсний дээд үе давхаргын (0-30 см) ялмагийн агууламж 0.1-1.6%, бүх үе давхарга карбонатжилттай, урвалын орчин 7.78-9.0 буюу дунд зэрэг шүлтлэгээс маш хүчтэй шүлтлэг, хялбар уусах давсжилт хужирлаг болон гөлтгөнө, хурдас бүхий хөрсний бүх үе давхаргад их (2.1-2.2 dS/m) агууламжтай, бусад хөрсөнд багаас дунд зэрэг буюу 0.1-0.52 dS/m байна. Хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд том ширхэгтэй элсэн фракц зонхилсон элсэнцэр бүрэлдэхүүнтэй. Нөлөөлөлд өртөөгүй ердийн хөрсний өнгөн үе

давхарга дахь хортой болон био-идэвхт хүнд металлын агууламж стандартын хүлцэх агууламжаас ноцтой хэтэрсэн тохиолдол байхгүй хэвийн түвшинд байна.

Гадаргын ус. Төлөвлөж буй автозамын трасс дагуу түүний ойр орчмын нутаг нь манай орны түр урсгал бүхий гол горхитой мужид хамаарна. Эндхийн газар нутаг хуурайдуу, салхи ихтэй ба усны ууршилт их явагдана. Тус бүс нутагт жилд усны гадаргаас уурших усны хэмжээ 1000 мм ба түүнээс их байна. Энэ нь жилд орох хур тунадаснаас 10 ба түүнээс олон дахин их гэсэн үг юм. Тус бүс нутгийн сайрууд цас их унасан жилд хавар шар усны үертэй, харин зун хур бороо болон эрчим ихтэй аадар борооны усаар тэжээгдэн түр урсгалтай болох ба үерлэнэ. Жилийн бусад хугацаанд сайр, гуу жалга, судаг урсацгүй. Хур бороо ихтэй услаг жилд, ялангуяа эрчимжил ихтэй түр зуурын хур борооны улмаас сайр, судаг, гуу жалга үерлэдэг. Энэ орчмын нутгийн гадаргуугийн хэрчигдэл их, сайрын сав газрын гидрологийн нөхцөл хүнд зэрэг байдал нь барилгын ажил гүйцэтгэхэд ихээхэн хүн хүч, зардал хөрөнгө, машин техник шаардах зэрэг бэрхшээл учруулахаар нөхцөлтэй. Замын нийт уртын дагуу түүнд хөндлөн эсвэл янз бүрийн өнцөг үүсгэсэн чиглэлд огтолсон сайр, судгуудын гулдирын хэвгий нь харилдан адилгүй, эхээс адаг хүртэлх дундаж хэвгий нэлээд их буюу 10-45 промилль байна. Иймээс сайруудад ширүүн урсгал ажиглагдана. Тачир сийрэг ургамалтай, сул, нуралтад өртөмхий, ихэнхдээ шавар агууламжтай хайрга чулуурхаг ба элс бүхий хөрстэй. Энэ газарт хур тунадасны урсцаар хөрс, чулуулгийн жижиг ширхгүүд зөөгдөж урсах, уул, толгодын хажуу бэл хормойн хур тунадаснаас үүсэх нэл урсац цугларах хэсэгт хөрсний эвдрэл хүчтэй үүсэж болно. Говь цөлийн бүс хэдийгээр

хур тунадас багатай, хуурай нутаг боловч хур тунадас, ялангуяа эрчим их, тур зуурын хүчтэй аадраар сайр, судгууд үерлэх нь өндөр магадлалтай хiii Сэкер Ресорсус Монголиа ХХК-ийн Хотгор чулуун нүүрсний уурхайгаас Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км авто замын төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан (Нэмэлт тодотгол) - 2024 он байдаг. Гэхдээ үер ховор тохиолдох ба богино хугацаанд ажиглагдах хэдий ч зам, ус зайлуулах байгууламжийг эвдлэх, машин техникийг урсгах зэрэг тохиолдол гарах магадлалтай.

Газрын доорх ус. Гидрогеологийн региональ зүй тогтлын хувьд тус бүс нутаг нь Өмнөд говийн бүсэд хамаарна. Тухайн бүс нутгийн физик газарзүй, геологийн тогтоц, тектоник зэрэг нөхцөлүүдийг харгалзан Хотгор-Шивээ хүрэн чиглэлийн замын трасс дагуу гидрогеологийн хэд хэдэн үндсэн структур ялгаж, структур тус бүрээр нь тухайн орчны гидрогеологийн нөхцөлийг тодорхойлсон байна. Өндөр өргөгдсөн уулсыг гидрогеологийн массив, уулс хоорондын хотгорыг гидрогеологийн бассейн гэж ялгадаг. Энэхүү замын трассын чиглэлд геологийн тогтоц буюу газрын доорх ус агуулах геологийн орчны хувьд хоорондоо ялгаатай хэд хэдэн гидрогеологийн массив болон бассейн ялгагдана. Газрын доорх ус агуулах геологийн орчин буюу гидрогеологийн структур нь бүс нутгийн геологийн хөгжлийн түүх, тектоник хөдөлгөөний өрнөл, эдгээрийн дараа хэлбэржин тогтсон орчин үеийн геологийн биетүүдийн хэлбэр зэргээс хамааран өөр өөрийн онцлогтой. Говь-Алтайн нуруу, түүний системд багтаж буй өмнөд хэсгийн бүс геологийн судалгааны үр дүнгүүдээс үзэхэд энэ бүс нутгийн геологийн үндсэн суурь нь палеозойн настай

чулуулгууд байх бөгөөд эдгээр нь палеозойн эринээс хойш олон удаагийн тектоник хөдөлгөөн, геологийн үйл явцын үр дүнд хэд хэдэн блок структурт хуваагдаж одоогийн уулсын үндсэн хэлбэр төрх бий болж, улмаар зэрэгцсэн, цуварсан хэсэг бүлэг уулс, тэдгээрийг өөр хооронд нь заагласан өргөн уудам бэл хөндийнүүд үүссэн байна. Улмаар мезо-кайнозойн эринд уулс хоорондын хөндийнүүдэд хурдас хуримтлал явагдан дүүргэгдэж, газрын доорх ус их хэмжээгээр агуулах боломжтой бассейнүүд буюу газрын доорх усны ай савууд үүссэн аж. Мезо-кайнозойн эриний төгсгөлийн шатанд бүс нутгийн хэмжээнд мөн тектоник хөдөлгөөн идэвхжиж өмнө үүсэн бий болсон гидрогеологийн үндсэн структурүүдийн хэлбэр зүйг өөрчлөн одоогийн хэлбэр төрхийг бий болгосон байна.

Ургамлан нөмрөг. Төлөвлөж буй авто замын трассын талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Алашаа говийн (цөлийн) тойргоос Говь Алтайн уулын цөлөрхөг хээрийн тойрог, Алтайн өвөр говийн (цөлийн) тойргуудад хамаарагддаг. Төслийн талбай болон тухайн орчмын нутаг дэвсгэр нь ургамлын экологи, тархах ургамлан нөмрөгөөрөө бүхэлдээ 4 хэв шинжид хамаарах 8 хэвшил, 15 бүлгэмдэл тархсан байна. Уг судалгаагаар төслийн талбайн болон түүний ойр орчмын цөл, цөлийн хээрийн ургамлан бүлгэмдлийг дагаж 22 овогт хамаарах 54 төрлийн 65 зүйл ургамал бүртгэгдсэн. “Монгол орны улаан ном” (2013)-ын ургамлын жагсаалтад орсон нэн ховор ургамал төслийн талбай орчимд тохиолдохгүй. “Монголын ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл” (2012) - д бүртгэгдсэн хамгааллын статустай ургамал *Amygdalus mongolicus* - Монгол бүйлс устаж болзошгүй, *Cariophyteris mongolica*- Монгол

Догар, *Peganum harmala* - Эгэл өмхий өвс эмзэг, *Arnebia gutata* - толбот бэрмэг анхааралд өртөхөөргүй ангиллаар орсон. БОАЖЯ-ны сайдын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/603 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт ургамлын жагсаалт”-д орсон ховор статустай 4 зүйл, элбэг статустай 34 зүйл тохиолдоно.

Амьтны аймаг. Судалгааны талбай нь Монгол улсын хөхтөн амьтны улаан дансны Бүс нутгийн тархалтын бүсчлэлээр Говь Алтай нуруу, Алтайн өвөр говь цөл, Алашаа говь цөлийн бүсэд хамаарна. Трассын дагуу талбайд 5 зүйл могой, 7 зүйл гүрвэл нийт 12 зүйл мөлхөгч амьтан тэмдэглэгджээ. Энд монгол орны хамгийн том гүрвэл болох Замба гүрвэл (*Laudakia stoliczanal*), цоохор хонин гүрвэл (*Phynoccephalus versicolor*), төмөр гүрвэл (*Alsophylax ripiens*), нохой гүрвэл (*Teratoscincus przewalskii*), могой гүрвэл (*Eramias multiocellata*), говийн гүрвэл (*Eramias przewalskii*), загалт гүрвэл (*Eramias mermiculata*), нарийн могой (*Coluber spinalis*), тэмээн сүүл могой (*Eryx tataricus*), сум могой (*Psammophis lineolatus*), рашааны могой (*Elaphe dione*), бамбай хоншоорт могой (*Gloydus halys*) бий. Трассын дагуух талбай орчимд жигүүртэн шувуудын 40 орчим зүйлийг илрүүлэв. Эдгээр зүйлүүдээс монгол улсын улаан номд бүртгэгдсэн шувуудаас хулан жороо цөөн таарав. Трассын дагуу тохиолдох голлох жигүүртний зүйлүүдийг амьдралын хэв маягаар нь ялгавал уулын бэл, аараг толгод, хадархаг хавцал, гуу жалга, асга чулуу, сухайн довцгоор хахилаг хив Сэкер Ресорсус Монголиа ХХК-ийн Хотгор чулуун нүүрсний уурхайгаас Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км авто замын төслийн Байгаль орчны

нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан (Нэмэлт тодотгол) - 2024 он ятуу, үетэн- таана, баглуурт хайрган хөрст дагжуур говь цөлөрхөг хээрт ногтруу, элсэн манхан сул элс, хармаг, сухай, бут сөөгт элсэн довцогт хулан жороо, хотны бүтээхэй, өндөр уулын хад цохио, хясаа, таг нугаар тас, ёл тохиолдоно.

Нийгэм, эдийн засаг. Баянхонгор аймаг нь 89,643 хүн амтай бөгөөд үүнээс 45,453 (50.7%) эмэгтэй, 44,190 (49.3%) эрэгтэй байна. Нийт хүн амын 32,665 нь аймгийн төвд, 10,017 нь сумуудын төвд, 46,961 хүн хөдөө амьдарч байна. Аймгийн хэмжээнд 26,737 өрхтэй бөгөөд үүний 72.7% буюу 19,432 өрх нь эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй, 27.3% буюу 7,305 өрх нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна. Нийт өрхийн 9,746 өрх нь аймгийн төвд, 3,057 өрх нь сумуудын төвд, 13,934 өрх нь хөдөө оршин сууж байна. Аймгийн нийт хүн амын 2.85% буюу 2,562 нь Шинэжинст суманд амьдарч байгаа бөгөөд үүний 49.25% буюу 1,262 хүн нь эрэгтэй, үлдсэн 50.75% буюу 1,300 хүн нь эмэгтэй байна. Сумын хэмжээнд 823 өрх оршин сууж байна. Өмнөговь аймаг нь 75,458 хүн амтай бөгөөд үүнээс 37,738 (50.01%) эрэгтэй, 37,720 (49.99%) эмэгтэй байна. Насны бүтцээр ангилбал 33.2 хувийг 0-14 насны хүүхэд, 59.5 хувийг 15-59 насны, 7.4 хувийг 60-с дээш насны хүн ам эзэлж байна. 2023 оны эцсийн байдлаар өрхийн тоо 25,338 болж өмнөх оноос 1,623 өрхөөр буюу 6.8 хувиар өссөн дүнтэй байна. Аймгийн нийт хүн амын 7% буюу 5,283 нь Гурвантэс суманд амьдарч байгаа бөгөөд үүний 50.5% буюу 2,668 хүн нь эрэгтэй, үлдсэн 49.5% буюу 2,615 хүн нь эмэгтэй байна. Сумын хэмжээнд 1,765 өрх оршин сууж байна.



БҮЛЭГ 3.

ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Хотгорын чулуун нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45км авто зам төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ЗГ-ын 2023 оны 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлалын дагуу байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч тусгасан.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй болон гол

сөрөг нөлөөллийг болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд, түүний үйлчлэлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нутгийн оршин суугчид, түүх, соёлын өвд бий болох сөрөг үр дагавар, түүний эрчим, цар хүрээ, шууд болон шууд бус нөлөөллүүд, болзошгүй нөлөөллийг Монгол улсын хууль тогтоомжид заасан болон олон улсын нийтлэг аргуудыг ашиглан үнэлсэн.

Төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээг магадлан жагсаах болон матрицын аргаар үнэлсэн. Үүнээс гол сөрөг нөлөөллийг ялган авч төслийн бүтээн байгуулалтын болон ашиглалтын үеийн нөлөөллийг Оноот үнэлгээний аргаар тус тус үнэлсэн.

Хүснэгт 1 Сөрөг нөлөөллийн үнэлгээ

№	Нөлөөлөл	Нөлөөллийн түвшин	Нөлөөллийн үнэлгээ
A	Фикик нөлөөлөл	-11	Дунд зэргийн сөрөг нөлөөтэй
A1	Агаарын чанарын нөлөөлөл	-9.25	Дунд зэргийн сөрөг
A2	Газрын гадарга, хэвлий	-15.3	Их сөрөг
A3	Хөрсөн бүрхэвч	-13	Дунд зэргийн сөрөг
A4	Ус	-6.5	Дунд зэргийн сөрөг
B	Биологийн олон янз байдал	-12	Дунд зэргийн сөрөг нөлөөтэй
B1	Ургамлан нөмрөг	-11.5	Дунд зэргийн сөрөг
B2	Амьтны аймаг	-12.5	Дунд зэргийн сөрөг
C	Нийгэм-Эдийн засгийн нөлөөлөл	+7.33	Бага зэргийн эерэг нөлөөтэй
C1	Ажил эрхлэлт, дэд бүтэц, эдийн засаг	+7.33	Бага зэргийн эерэг
	Нийт нөлөөлөл	-8.67	Бага зэргийн сөрөг нөлөөтэй буюу зөвшөөрөх боломжтой

Төслийг хэрэгжих явцад байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн түвшинг тогтоох зорилгоор эерэг болон сөрөг нөлөөллүүдийг жагсааж нөлөөллийн үргэлжлэх хугацаа, үйлчлэх хүрээг шинжилж хувийн жинг тодорхойлох замаар шинжилгээ хийв. Нийт нөлөөллийн 67.5% нь шууд, 20% нь шууд бус буюу болзошгүй сөрөг нөлөөлөлд хамаарна.

Нөлөөллийн 65% нь дунд хугацааны нөлөөлөлд 22.5% нь урт хугацааны, 12.5% нь богино хугацааны сөрөг нөлөөлөлд хамаарна. Нөлөөллийн шинжилгээнээс үзэхэд нийт нөлөөллийн 24% нь эерэг, 32% нь бага зэргийн хүчтэй, 30% нь дунд зэргийн хүчтэй, 14% нь их хүчтэй нөлөөлөлд тус тус хамаарч байна.



БҮЛЭГ 4.

**ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

4. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн авто замын барилгын ажилд 2025 оны 3 дугаар сарын 05-ны өдөр Багц-5-ийн Гүйцэтгэгч болох Монгол Улсын Зэвсэгт Хүчний Барилга-Инженерийн Цэргийн Удирдах Газар төслийн талбайд хүрэлцэн ирж бэлтгэл ажлаа эхлүүлснээр эхэлж бусад багцын Гүйцэтгэгчид болон Ерөнхий гүйцэтгэгчийн түрээслүүлэгчид Захиалагчтай гэрээ байгуулсан он сарын дарааллаараа төслийн талбайд хүрэлцэн ирж төслийн авто замын барилгын ажил болон бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Тайлант хугацааны эцсийн байдлаар төслийн талбайд нийт 12 Гүйцэтгэгч 8 багцад авто замын барилгын ажлын өөр өөр шатанд ажил гүйцэтгэж байна. Үүнээс голлох ажлыг дурдвал:

- Ажлын зураг болон аргачлал боловсруулах
- Газрын гадаргын түвшний хэмжилт хийх
- Шороон ордууд болон ухмалуудаас дээж авч, Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх
- Түр замын барилгын ажил хийх
- Түр замын засвар, арчлалт хийх
- Замын зурвас дахь бут сөөгийг тайрч зайлуулах
- Ул хөрс тэгшилж нягтруулах

- Экскаватороор ухмал байгуулах
- Далангийн дүүргэлтийн ажил,
- Далангийн дээд үеийн барилгын ажил,
- Суурийн дэд суурь байгуулах,
- Цементээр бэхжүүлсэн байгалийн хөрсөн суурь байгуулах,
- Хоолойн байршил тогтоох
- Хоолойн суурийн ухмал хийх
- Хоолойн зохист ширхэглэлтэй хайрган суурь байгуулах
- Атираат ган хоолойг угсарч бэлтгэх,
- Ус тусгаарлагч битум түрхлэг хийх,
- Хоолойн буцаан дүүргэлт хийх

Тайлант хугацааны эцэс гэхэд төслийн талбайд нийт 12 Гүйцэтгэгчийн 1,049 хүн хүч, 730 техник тоног төхөөрөмж ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 412,303.51м³ ухмалын ажил, 741,162.7м³ шороон ордоос зөөврөөр далан байгуулах, 165,547.23м³ далангийн дээд үе байгуулах, 56,880.3м³ цементээр бэхжүүлсэн суурь тус тус хийгдээд байна. Гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээг дэлгэрэнгүй байдлаар доорх хүснэгтэд үзүүлэв.

4.1 Гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээний төлөв

Хүснэгт 2 Гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ

№	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ	Өмнөх сард		Энэ сард		Нийт		Гүйцэтгэл хувиар	
				Гүйцэтгэсэн	Баталгаажсан	Гүйцэтгэсэн	Баталгаажсан	Гүйцэтгэсэн	Баталгаажсан	Гүйцэтгэсэн	Баталгаажсан
25-01-00 Түр барилга үйлдвэрлэлийн бэлтгэл ажил											
1	Ажилтнуудын зөөврийн сууц байрлуулах	ш	23	23	23			23	23	100%	100%
2	Гал тогооны зөөврийн сууц байрлуулах	ш	6	6	6			6	6	100%	100%
3	Усны нөөцийн сав байрлуулах	ш	12	8	8	4	4	12	12	100%	100%
4	Контейнер байгуулах /агуулахын зориулалттай, 40тн/	у/м	6	6	6			6	6	100%	100%
5	Шатахууны агуулах сав байгуулах /50тн/	ш	6	6	6			6	6	100%	100%
6	Халуун усны зөөврийн байр байгуулах	ш	6	6	6			6	6	100%	100%
7	Оффисын зөөврийн сууц байрлуулах	ш	6	6	6			6	6	100%	100%
8	Галын постын түр байр байгуулах	ш	6	6	6			6	6	100%	100%
9	Арматур болон төмөр хийц, бүтээц боловсруулах төхөөрөмж байрлуулах	ш	7	-	-		2	2	2	28.5%	28.5%
10	Харуул хамгаалалтын арга хэмжээ авах	сар	86.57	10	10	12	12	22	22	25.4%	25.4%
11	Зөөврийн био 00 /нойл/ байрлуулах	сар	79.65	10	10	12	12	22	22	27.6%	27.6%
25-02-00 Замын чиг сэргээх, гадаслах											
1	Замын чигийг сэргээх /GPS/	км	295.137	274.4	274.4	0	0	0	0	93%	93%
25-04-00 Замын трасс, талбайн цэвэрлэгээний ажил											

1	Замын зурвас дахь бут сөөгийг тайрч зайлуулах	м2	2,280,550.0	1,308,280.88	1,293,946.88	97,263.4	101,328	1,405,544.28	1,395,274.88	61.6%	61.2%
2	Бульдозероор ургамлын үе хуулах	м3	31,100.0	25,600	25,600	0	0	25,600	25,600	82.3%	82.3%
3	Экскаватороор ургамлын үе хуулах	м3	125,000.0	110,867.42	110,867.42	0	0	110,867.42	110,867.42	97.7%	97.7%
4	Автогрейдерээр ургамлын үеийг хуулах	м3	76,090.80	65,559.95	18,580.81	5,734	7,399.63	75,293.95	25,980.44	99%	34.1%
5	Ул хөрс тэгшлэх, нягтруулах	м2	6,369,962.0	2,815,378.82	2,548,929.17	96,372	128,085.4	2,911,750.82	2,677,014.57	45.7%	42%
6	Замын зурвас дахь жижиг модыг бульдозероор үндсээр нь түрэх ба модыг 20м хүртэл зайд түрж зайлуулах	га	3.0	1.29	1.29	0.51	0	1.8	1.29	60%	43%
25-05-00 Карьер, шороон орд нээх, нөхөн сэргээх ажил											
1	Шороон орд нээх	м3	33,000.0	24,000	24,000	1,000	1,000	25,000	25,000	75.8%	75.8%
2	Шороон ордод техникийн нөхөн сэргээлт хийх	м3	37,000.0	-	-	-	-	-	-		
25-06-00 Түр болон туслах замын ажил											
1	Түр зам байгуулах	км	295.137	265.52	177	5.25	15	270.77	192	91.7%	65.1%
25-07-00 Замын далан, ухмалын ажил											
1	Экскаватороор ухмал байгуулах	м3	1,710,448.54	895,187.68	620,286.7	412,303.51	322,863.77	1,307,491.19	943,150.47	76.4%	55.1%

2	Хатуу материалын ухмал ухаж, суллах	м3	369,094.0		21,955	0	19,764.34	0	41,719.34	0	11.3%	0%
3	Шороон ордоос зөөврөөр далан байгуулах	м3	2,310,685.0		1,052,917.95	824,254	741,162.7	654,520.63	1,794,080.65	1,478,774.63	77.6%	64%
4	Ухмалаас зөөврөөр далан байгуулах	м3	728,887.0		174,941.62	117,087.62	18,821.86	2,345.86	193,763.48	119,433.48	26.6%	16.4%
5	Далангийн дээд үе байгуулах	м3	1,125,139.0		131,199.5	95,129.81	165,547.23	96,816.96	296,746.73	191,946.77	26.4%	17.1%
6	Дэд суурь	М3	1,047,610.0		79,850.7	40,372.97	56,880.3	30,672.9	136,731	71,045.87	13.1%	6.8%
7	Цементээр бэхжүүлсэн хөрсөн суурь хийх	М3	517,285		8,081.09	8,081.09	30,535.6	29,302.1	38,616.69	37,383.19	7.5%	7.2%
8	Хайрган хөвөө байгуулах	М3	997,329.072		3,180	0	28,827	28,181.77	32,007	28,181.77	3.2%	2.8%
9	Хоолойн суурийн ухмал	м3	33,448.38		9,614.24	9,614.24	0	0	9,614.24	9,614.24	28.7%	28.7%
10	Хоолойн ул суурь нягтруулах	м2	37,080.21		8,512.1	8,512.1	751.62	751.62	9,263.72	9,263.72	25%	25%
11	Хоолойн суурийг зохист ширхэглэл бүхий элс хайргаар байгуулах	м3	16,686.55		3,634.45	3,634.45	414.07	414.07	4,048.52	4,048.52	24.3%	24.3%

12	Элсэн дэвсгэр үе байгуулах	М3	4,000	927.5	927.5	147.36	147.36	1,074.86	1,074.86	26.9%	26.9%
13	Атираат ган хоолой суурин дээр байрлуулах, D1000	у/м	11,052.77	3,126.38	3,126.38	145.27	145.27	3,271.65	3,271.65	29.6%	29.6%
14	Атираат төмөр хоолой суурин дээр угсрах, D1500	у/м	2,159.62	118.06	118.06	288.78	288.78	406.84	406.84	18.8%	18.8%
15	Буцаан дүүргэлтийг байгалийн зохист ширхэглэл бүхий хөрсийг 5%-ийн цементээр бэхжүүлж хийх	м3	37,623.23	6,097.3	6,097.3	957.03	957.3	7,054.33	7,054.33	18.7%	18.7%
16	Түрхмэл ус тусгаарлагч хийх	м2	62,672.08	15,747.16	15,747.16	1,490.34	1,490.34	17,237.5	17,237.5	27.5%	27.5%

Хүснэгт 3 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн зардлын задаргаа

4.2 Төслийн авто замын үндсэн өгөгдлүүд

Төслийн авто зам нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Нарийнсухайт - Шивээхүрэн чиглэлийн нүүрс тээврийн замтай холбох юм.

Төслийн авто замын эхний хэсэг нь 295.137км урт бөгөөд 2Б зэрэглэл, тусгай зориулалтын хуримтлуулагч зам бөгөөд үүний дагуу төлөвлөлтийн үндсэн элементүүдийг дараах байдлаар сонгож авсан байна.

- Тооцоот хурд: 60 км/цаг.
- Далангийн өргөн: 16м,
- Зорчих хэсгийн өргөн нь 8м,
- Хөвөөний өргөн: хоёр талдаа тус бүр 4м

- Хэвтээ болон босоо муруйнууд одоо мөрдөгдөж байгаа “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016-ын дагуу төлөвлөгдсөн.

Хучилтын хийц нь:

1. 5см асфальт бетон хучилт,
2. 20см цементээр бэхжүүлсэн буталсан чулуун суурь /6% хүртэл цемент/,
3. 20см цементээр бэхжүүлсэн хөрсөн суурь /5% хүртэл цемент/,
4. 20см дэд суурь, 30- дээш CBR
5. 20см далангийн дээд үе 20-иос дээш CBR-тай байхаар төлөвлөгдсөн болно.

Төслийн авто замыг багцад хуваасан байдал

Төслийн замын нийт урт нь 295.137 км бөгөөд Захиалагч “Сэкер Ресорсус Монголиа” ХХК нь төслийн замыг богино хугацаанд барьж дуусгахын тулд олон туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулж төслийн авто замыг олон багцад хуваан гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнд:

- a) **Багц-1 (67км):** Авто замын урт нь K0+000-K67+000 хүртэлх 67 км авто замын хэсэг бөгөөд Гүйцэтгэгч “Чайна Рейлвей Ферст Групп Монголиа” ХХК-ийн 1-р хэсэг нь Захиалагчтай ажил гүйцэтгэх гэрээг 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр байгуулсан.
- b) **Багц-2 (43км):** Авто замын урт нь K67+000-K110+000 хүртэлх 43 км авто замын хэсэг бөгөөд Гүйцэтгэгч “Чайна Рейлвей Ферст Групп Монголиа” ХХК-ийн 2-р хэсэг нь Захиалагчтай ажил гүйцэтгэх гэрээг 2025 оны 5 дугаар сарын 7-ны өдөр байгуулсан.
- c) **Багц-3 (50км):** Авто замын урт нь K110+000-K160+000 хүртэлх 50 км авто замын хэсэг бөгөөд Гүйцэтгэгч “Чайна Рейлвей Ферст Групп Монголиа” ХХК-ийн 3-р хэсэг нь Захиалагчтай ажил гүйцэтгэх гэрээг 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр гэрээ байгуулсан.
- d) **Багц-4А (10км):** Авто замын урт нь K160+000-K170+000 хоорондох хэсгийн 30км авто зам бөгөөд уг хэсгийн Гүйцэтгэгчээр “Хишиг Баян Зам” ХХК шалгарч Захиалагчтай ажил гүйцэтгэх гэрээг 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан.
- e) **Багц-4В (20км):** Авто замын урт нь K170+000-K190+000 хоорондох хэсгийн 20км авто зам бөгөөд уг хэсгийн Гүйцэтгэгчээр “Толигор бодь зам” ХХК шалгарч Захиалагчтай ажил гүйцэтгэх гэрээг 2025 оны 8 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан.
- f) **Багц-5 (50км):** Авто замын урт нь K190+000-K240+000 хүртэлх 50км авто зам бөгөөд уг хэсгийн Гүйцэтгэгчээр Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн Цэргийн Удирдах Газар шалгарч Захиалагчтай ажил гүйцэтгэх гэрээг 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан.
- g) **Багц-6 (10км):** Авто замын урт нь K240+000-K250+000 хүртэлх 10км бөгөөд уг хэсгийн Гүйцэтгэгчээр “Бриджлайф” ХХК шалгарч Захиалагчтай ажил гүйцэтгэх гэрээг 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан.
- h) **Багц-7 (10км):** Авто замын урт нь K250+000-K260+000 хүртэлх 10км бөгөөд уг хэсгийн Гүйцэтгэгчээр “Хүлгийн Дээд” ХХК шалгарч Захиалагчтай ажил гүйцэтгэх гэрээг 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан.
- i) **Багц-8 (14,4км):** Авто замын урт нь K260+000-K270+000 хүртэлх 10км бөгөөд уг хэсгийн Гүйцэтгэгчээр “Арвижих Алтан Говь” ХХК шалгарч Захиалагчтай ажил гүйцэтгэх гэрээг 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан. Мөн K270+000-K274+400 хүртэл дахин авч K260+000-K274,400 хүртэл 14,4км хийж гүйцэтгэхээр болсон.
- j) **Багц-9 (15,137км):** Одоогоор энэ хэсгийн гүйцэтгэгч шалгараагүй байна



БҮЛЭГ 5.

**СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ
БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт-2 Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж, хугацаа	Биелэлт
1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
1	Замын ажилд шаардлагатай элс шаврыг карьераас олборлоход агаарт тоосжилт үүсэх	Карьераас материал олборлолтын үед болон газар шорооны ажлын үед усалгаа хийх	карьерууд	барилгын ажил явагдах үед	Баянхонгор аймгийн Шинэжинст сумаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45км замын барилгын ажил 2025 оны 03 сараас эхний авто замын барилгын ажил эхлэсэн. Замын ажилд ашиглах карьеруудруу түр замыг хийсэн байх бөгөөд түр замын усалгааг хийж бүртгэлжүүлсэн.
2	Зам барилгын ажлын үед тэр замаас агаарт тоосжилт үүсэх	Зам барилгын үед түр замын тогтмол маршрутыг төлөвлөж, шаардлагагүй олон салаа зам гаргахгүй байх.	түр зам	барилгын ажил явагдах үед	Зам барилгын ажил эхлэхээс өмнө гүйцэтгэгч нар түр замын маршрутыг Захиалагч, зөвлөх, хяналтын үйлчилгээ үзүүлж буй Ай Си Ти Сайн Консалтинг ХХК, Баянхонгор аймгийн Замын цагдаагийн тасаг, Гурвантэс сумын цагдаагийн тасагтай хамтран маршрутын зургийг баталж тус маршрутыг дагуу олон салаа зам гаргахгүй байх талаарх шаардлага тавин ажиллаж байна.
3		Засаж сайжруулсан түр замаас гаргахгүйн тулд стандартын дагуу тэмдэгжүүлэх, ухуулах самбар байршуулах,	Түр зам	Жил бүрийн	Нийт авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа 12 гүйцэтгэгч компаниуд засаж сайжруулсан түр замаас гаргахгүйн аюулгүй байдлыг

					хангах үүднээс MNS4597 2014 Автозамын тэмдэг, техникийн ерөнхий шаардлагын дагуу тэмдэгжүүлэх, ухуулах самбар байршуулж, батлагдсан түр замын маршрутын дагуу гүйцэтгэгч нар нийт 260ш захиалагч зүгээс тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байна,
4		Түр замын дагуу тээврийн хэрэгслийн хурдны хязгаарлалт хийх, хурдны хязгаар тогтоосон дотоод журам боловсруулан хэрэгжүүлэх	түр замууд	хөдөөлгөөн хийгдэж байгаа тохиолдол бүрд	Сэкер ресорсус монголиа ХХК-н замын хөдөлгөөний журам батлуулж авто замын ажил гүйцэтгэгч нарт дагаж мөрдөхийг үүрэг болгосон бөгөөд замын батлагдсан маршрутын дагуу хурдын хязгаарлалтын тэмдэгийг байршуулсан.
5		Түр шороон замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор засвар арчилгааны тогтсон хуваарийг гаргаж, хуваарийн дагуу замыг засаж сайжруулах, нягтаршуулах	Түр зам	авто замын барилгын ажлын явцад	Сэкер ресорсус монголиа ХХК нь авто замын барилгын ажлын үед гарах тоосжилтыг бууруулах зорилгоор замын трассын дагуу нийт 24 гүний худгийг өөрийн хөрөнгөөр тохижуулж гүйцэтгэгч компаниудад хүлээлгэн өгч усалгааны хувиар бүртгэл гарган усалгааг хийж, туурин үүссэн бороо үерийн улмаас эвдрэлд орсон туурин үүссэн тохиолдолд нягтаршуулах арга хэмжээг тухай бүр нь авч хэрэгжүүлсэн болно.
6	Зам барилгын үйл ажиллагаанаас агаарт тоосжилт үүсэх	Зам барилгын ажлын үед тоосжилт ихээр үүсэхээс сэргийлж газар шорооны ажлын үед усалгаа хийх	Зам барилгын талбай	Барилгын ажил явагдах саруудад	Дээр дурьдсанчилан өрөмдөж хүлээлгэн өгсөн худгуудаасаа үнсэн болон түр замын усалгааг хийж бүртгэлжүүлсэн бөгөөд одоогоор Шинэжинст суманд байрлах 3

					худгаас нийт 32477м ³ усыг зам барилгын ажилд ашигласан байна.
7	Зам барилгын ажилд ашиглах хүнд даацын тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас агаар бохирдуулагч хийнүүд ялгарах	Тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрийн яндангаас орчны агаарт бий болгох бохирдлыг багасгах үүднээс үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийлгэж байх,		Үйл ажиллагааны турш	Авто замын барилгын ажил гүйцэтгэж буй компаниуд ашиглаж буй машин техникийг үзлэг оношилгоог хийлгэж, барилгын ажлын явцад эвдрэл гэмтэл үүссэн тохиолдолд техник засвар үйлчилгээг хийж байсн.

5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр түр зам болон карьераас материал олборлолтын үеийн зам усалгаа.

Автозамын барилгын ажил нь 2025 оны 3-р сарын 15-наас эхний гүйцэтгэгч талбайд гарсан бөгөөд барилгын ажил 4 сарын 20-ноос Гурвантэс сумын хэсгээс эхлэсэн. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт 67км Гурвантэс сумын нутагт 221.45км тусгай зориулалтын авто зам барих ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор зам барилгын ажилд ашиглах шороон орд буюу түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглах зөвшөөрлийг Баянхонгор аймгийн Засаг дарга, Өмнөговь аймгийн Засаг даргад хүсэлт тавьсны дагуу Засаг даргын захирамжын дагуу Шинэжинст суманд 15 карьер, Гурвантэс суманд 17 байршилд ТТАМ ашиглах зөвшөөрөл олгогдсон.

Дээрх ТТАМ ашиглах үед гарах тоожилтыг бууруулах зорилгоор нийт 24-н байршилд гүний худаг гаргахаар төлөвлөсөн. Түүний дагуу гүний худагуудыг өрөмдөх ажлыг

ЦМ Ундарга ХХК болон Гранд холдинг ХХК болох эрх бүхий мэргэжлийн компаниар хамтын ажиллагааны гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. 2024 оны 8-н сараас эхлэн өрөмдлөгийн ажлыг эхлүүлж одоогийн байдлаар Шинэжинст сумын нутагт авто замын трассын дагуу 4-н байршилд, Гурвантэс сумын нутагт 20-н байршилд тус тус 2л/с дээш ундаргатай худгийг өрөмдөж тоноглон карьераас материал олборлох үед үүсэх тоосжилтыг бууруулах арга хэмжээг авч ашиглаж байна.

Карьерийн түр замын усалгаанд ус ашиглах гэрээгээр заасан хэмжээнд ашигласан бөгөөд нийт 4608м³ куб орчим ус ашигласан байна. Шинэжинст сумын нийт 67км замын түр замын усалгаанд үйл ажиллагаа явуулж байгаа 4-н гүйцэтгэгч компани 8-н усны машин Гурвантэс сумын авто замын үйл ажиллаганд



Зураг 2 Карьер болон түр зам усалгаа





Зураг 3 Карьерийн түр замын усалгаа

БАТЛАВ:
ТАЛЫН НӨМӨГӨН ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Г.УЛАМБАЯР
2025 оны 08 сарын 01-ний өдөр

Түр замын усалгаа хийх тухай

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км хатуу хучилттай авто замын төслийн 1-р хэсэг дэх ПК 2+000-ПК 6+000 км авто замын түр замын усалгааг дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хур бороотой үед долоо хоногт 1 удаа;
2. Цаг агаарын нөхцөл хуурай, хур бороо багатай бол долоо хоногт 3 удаа;
3. Шаардлагатай тохиолдолд өдөр бүр услах.

Хариуцах эзэн:

- Хуваарийн дагуух усалгааг талбайн инженер хариуцан хэрэгжүүлнэ.
- Байгаль орчны мэргэжилтэн хяналт тавина.

Хэрэгжүүлэх горим:

- Усалгаа бүрийг фото зургаар баталгаажуулах.
- Усны бүртгэлийг хөтлөх ба усалгааны бүртгэлд огноо, ашигласан усны хэмжээ, жолоочийн гарын үсгээр баталгаажуулна.

oOo

БАТЛАВ:
"ӨСӨХ УРАМ" ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
С.МАЙНБАР
2025 оны 08 сарын 01-ний өдөр

Түр замын усалгааны хуваарь

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төслийн гүйцэтгэгч "Өсөх урам" ХХК ПК 16+000 – ПК 67+000 хэсгийн түр замын усалгааны хуваарийг хур бороотой үед долоо хоногт нэг удаа, цаг агаарын нөхцөл хуурай хур бороо бага нөхцөлд долоо хоногт гурван удаа хийх. Шаардлагатай тохиолдолд өдөр бүр услах.

Хуваарийн дагуух усалгааг талбайн инженер хариуцан хэрэгжүүлж, байгаль орчны мэргэжилтэн хяналтыг тавьж ажиллах.

Усалгаа бүрийг тухайн цаг хугацаанд фото зургаар баталгаажуулж, усны бүртгэлийг хөтлөх. Усалгааны бүртгэлд огноо болон ашигласан усны хэмжээ, жолоочийн гарын үсэг байх.

2025 оны 08 дугаар сарын 01-ний өдөр

БАТЛАВ: "УУЖИМ ХАРГИЙ" ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Б.БАТСУРЬ
2025 оны 08 сарын 01-ний өдөр

ТҮР ЗАМЫН УСАЛГАА ХИЙХ

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км урт хатуу хучилттай авто замын төслийн нэгдүгээр хэсэг К06+000-К11+000 5 километр авто замын түр замын усалгааг доорх байдлаар хийж хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

1. Хур бороотой үед долоо хоногт 1 удаа
2. Цаг агаарын нөхцөл байдал хуурай, хур бороо багатай үед долоо хоногт 3 удаа
3. Шаардлагатай тохиолдолд өдөр бүр усалгааг хийх

Хариуцах эзэн:

- Хуваарийн дагуу усалгааг талбайн инженер хариуцна
- Байгаль орчны мэргэжилтэн хяналт тавина.

Хэрэгжүүлэх горим:

- Усалгаа бүрийг фото зургаар баримтжуулна.
- Усны бүртгэлийг хөтлөх, усалгааны бүртгэлд огноо, ашигласан усны хэмжээ, жолоочийн гарын үсгээр баталгаажуулна.

БАТЛАВ:
"ӨСӨХ УРАМ" ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
С.МАЙНБАР
2025 оны 08 сарын 01-ний өдөр

Түр зам усалгаа, арчилгаа, үйлчилгээний хуваарь

Усалгаа хийх хуваарь

Усалгааны төрөл	Даваа	Мягмар	Лхагва	Баасан	Бямба	Ням
Түр зам						
Далан						
Кемп						
Шороон срд						

Замын засвар арчилгаа хийх хуваарь

Засварын төрөл	Даваа	Мягмар	Лхагва	Баасан	Бямба	Ням
Нүх бөглөх						
Тэгшилж илчлэх						
Хог цэвэрлэгээ						

БАТЛАВ:
ХҮЛГИЙН ДЭЭД ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ДЕНДОН
2025.05-2025.10

ЗАМ АРЧИЛГАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУВААРЬ

д/д	Хугацаа	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	05.01-05.14	экскаватороор карьер ухаж хөрс ачих, материал тээвэрлэх, автогрейдерээр тэгшлэх, нягтруулах, услах	Хаврын эхний арчилгаа
2	05.15 – 05.28	Замын тэгшлэл шалгах, усалгааг нэмэгдүүлэх	Тоосжилт бууруулах
3	05.29 – 06.11	Карьерын материал нөхөн татах, нягтруулалт	Бороо орсны дараах засвар
4	06.12 – 06.25	Автогрейдерээр тэгшилгээ хийх, услах	Хаврын төгсгөл
5	06.26 – 07.09	Замын хөндлөн нүх, эвдрэл засах	Бороо ихтэй үеийн арчилгаа
6	07.10 – 07.23	Нягтруулалт, тэгшилгээ, усалгааг давтан хийх	
7	07.24 – 08.06	Хайрга нөхөх, карьераас материал татах	
8	08.07 – 08.20	Замын гадаргуу тэгшлэх, услах	
9	08.21 – 09.03	Эвдрэл гэмтэл засах, ус зайлуулах хяналт	
10	09.04 – 09.17	Замын тэгшилгээ, нягтруулалт	Намрын арчилгаа эхэлнэ
11	09.18 – 10.01	Карьероос материал татаж нөхөх, услах	
12	10.02 – 10.15	Замын гадаргуу шалгах, хөлдөхөөс өмнөх засвар	
13	10.16 – 10.29	Эцсийн арчилгаа, өвөлжилтийн бэлтгэл	


ХУВААРЬ ГАРГАСАН: ХАБЭА-Н АЖИЛТАН С.ПҮРЭВСҮРЭН




Зураг 4 Усалгааны хуваарь

5.2 Түр замын батлагдсан маршрут

Авто замын барилгын ажил гүйцэтгэж буй 12 гүйцэтгэгч компани зам барих үед олон салаа зам гаргахгүй байх бодлогын хүрээнд Баянхонгор аймгийн замын цагдаагийн тасаг, Гурвантэс сумын замын цагдаагийн хэсэг болон замын ажлын зөвлөх үйлчилгээ үзүүлж буй АЙ СИ ТИ САЙН КОНСАЛТГ ХХК-гаар авто замын түр


замын маршрутыг батлуулж, байршлуудад тэмдэг тэмдэглэгээ байршуулах ажлыг гүйцэтгэсэн. Аль болох олон салаа зам гаргахгүй, талбай талхлахгүй байх талбайн зааварчилгааг өгч, хориглох тэмдэглэгээг байршуулж, салаан зам гарсан тохиолдолд ихэсгэхгүй байх үүднээс хаалт хийж зэрэг арга хэмжээг авч ажилласан.

Гүйцэтгэгч компани	Түр замын мартрут	Зурагт тайлбар																																				
“Талын нөмөр” ХХК	ПК0- ПК4.154км хоорондох	 <p>БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН "ХОТГОР" АН УУРХАЙГААС ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНТЭС СУМЫН НАРИЙНСУХАЙТЫН НҮҮРС ТЭЭВРИЙН ЗАМ ХҮРТЭЛХ 288.45 КМ УРТ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ПУТНИЙ ХАШААНААС ПК0+000 - ПК4+154.45 ХООРОНДОХ ТҮР ЗАМЫН ЗУРАГ</p> <table border="1" data-bbox="853 795 981 884"> <thead> <tr> <th>№</th> <th>X</th> <th>Y</th> </tr> </thead> <tbody> <tr><td>1</td><td>521367.78</td><td>4936261.95</td></tr> <tr><td>2</td><td>521534.11</td><td>4936255.12</td></tr> <tr><td>3</td><td>522131.06</td><td>4936221.32</td></tr> <tr><td>4</td><td>523195.89</td><td>4935792.27</td></tr> <tr><td>5</td><td>523649.55</td><td>4935706.32</td></tr> <tr><td>6</td><td>523790.2</td><td>4935508</td></tr> <tr><td>7</td><td>523967.63</td><td>4935167.96</td></tr> </tbody> </table>	№	X	Y	1	521367.78	4936261.95	2	521534.11	4936255.12	3	522131.06	4936221.32	4	523195.89	4935792.27	5	523649.55	4935706.32	6	523790.2	4935508	7	523967.63	4935167.96												
№	X	Y																																				
1	521367.78	4936261.95																																				
2	521534.11	4936255.12																																				
3	522131.06	4936221.32																																				
4	523195.89	4935792.27																																				
5	523649.55	4935706.32																																				
6	523790.2	4935508																																				
7	523967.63	4935167.96																																				
	ПК2- ПК6+000км хоорондох	 <p>Баянхонгор аймгийн Шинэжинст сумын "Хотгор" ан уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайт нүүрс тээврийн зам хүртэлх 295.137 км урт хатуу хучилттай авто замын түр замын зураг</p> <table border="1" data-bbox="853 1131 981 1265"> <thead> <tr> <th>№</th> <th>X</th> <th>Y</th> </tr> </thead> <tbody> <tr><td>1</td><td>51982.643</td><td>4936312.483</td></tr> <tr><td>2</td><td>52228.55</td><td>493608.558</td></tr> <tr><td>3</td><td>52388.823</td><td>493599.259</td></tr> <tr><td>4</td><td>523980.288</td><td>493583.095</td></tr> <tr><td>5</td><td>52402.428</td><td>493568.784</td></tr> <tr><td>6</td><td>524829.274</td><td>493462.247</td></tr> <tr><td>7</td><td>524860.828</td><td>493370.881</td></tr> <tr><td>8</td><td>524860.153</td><td>493364.207</td></tr> <tr><td>9</td><td>524860.309</td><td>493364.241</td></tr> <tr><td>10</td><td>524842.434</td><td>493278.585</td></tr> <tr><td>11</td><td>524842.437</td><td>493271.142</td></tr> </tbody> </table>	№	X	Y	1	51982.643	4936312.483	2	52228.55	493608.558	3	52388.823	493599.259	4	523980.288	493583.095	5	52402.428	493568.784	6	524829.274	493462.247	7	524860.828	493370.881	8	524860.153	493364.207	9	524860.309	493364.241	10	524842.434	493278.585	11	524842.437	493271.142
№	X	Y																																				
1	51982.643	4936312.483																																				
2	52228.55	493608.558																																				
3	52388.823	493599.259																																				
4	523980.288	493583.095																																				
5	52402.428	493568.784																																				
6	524829.274	493462.247																																				
7	524860.828	493370.881																																				
8	524860.153	493364.207																																				
9	524860.309	493364.241																																				
10	524842.434	493278.585																																				
11	524842.437	493271.142																																				
“Уужим харгуй” ХХК	ПК6+000- ПК11+000км хоорондох	 <p>Таних тэмдэг: түр зам, одоо байгаа дагын зам, шороон орд</p> <table border="1" data-bbox="901 1736 981 1825"> <thead> <tr> <th>№</th> <th>X</th> <th>Y</th> </tr> </thead> <tbody> <tr><td>1</td><td>524538.55</td><td>4931785.26</td></tr> <tr><td>2</td><td>524664.51</td><td>4931511.87</td></tr> <tr><td>3</td><td>524789.26</td><td>4931203.44</td></tr> <tr><td>4</td><td>524962.26</td><td>4930948.53</td></tr> <tr><td>5</td><td>525217.97</td><td>4930320.83</td></tr> <tr><td>6</td><td>525334.02</td><td>4930211.1</td></tr> </tbody> </table>	№	X	Y	1	524538.55	4931785.26	2	524664.51	4931511.87	3	524789.26	4931203.44	4	524962.26	4930948.53	5	525217.97	4930320.83	6	525334.02	4930211.1															
№	X	Y																																				
1	524538.55	4931785.26																																				
2	524664.51	4931511.87																																				
3	524789.26	4931203.44																																				
4	524962.26	4930948.53																																				
5	525217.97	4930320.83																																				
6	525334.02	4930211.1																																				

<p>“Тэргүүн жинст Би Ар Си Роуд” ХХК</p>	<p>ПК11- ПК16+000км хоорондох</p>																																																																									
<p>“Өсөх Урам” ХХК</p>	<p>ПК16- ПК67+000км хоорондох</p>																																																																									
<p>Хөдөлгөөний аюулгүй байдлын схем</p>																																																																										
16	Автын тэнхлэгний тэнхлэг, тэнхлэг, тэнхлэг, тэнхлэг, тэнхлэг, тэнхлэг эхэл	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	Турал
17	Сурвалж бүрэн тэнхлэг эхэл	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	Турал
18	Хөдөлгөөн тэнхлэг, хөдөлгөөн тэнхлэг эхэл	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	Турал
19	Дугуй тэнхлэг эхэл	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	Турал
20	Дугуй тэнхлэг эхэл	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	Турал

Шалгагчийн нэвтрэл: Ц.Х. ЦОЛГО
Ажил хариуцагч: Ц.Х. ЦОЛГО
Уламжлал: 05-00-000
Огноо: 2023.02.14

Technical inspection certificates for vehicles 91985BX, 91985BY, and 91985BZ. Each certificate includes details such as vehicle type (Dumper truck), engine number, chassis number, and inspection date (2023-02-14). The certificates are issued by the State Road and Transport Administration of Mongolia.



Зураг 10 Техникийн үзлэг оношилгоонд орж тэнцсэн тухай

5.7 Хөрсөн бүрхэвч газрын гадаргад үзүүлэх нөлөөллийг бууруулах

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж, хугацаа	Биелэлт
1	Төслийн үйл ажиллагаагаар нийт 4,320.0 мян.м ³ шимт хөрс хуулна.	Зам байгуулах, карьераас олборлолт хийх, ажилчдын кемп байгуулах зэрэг талбайн шимт хөрсийг зохистой зузаанаар хуулж тусад нь хадгалах	Төслийн талбай	Үйл ажиллагааны турш	Хөрсний судалгаанд замын трассын 1.5км буюу нийтдээ 3-км орчим өргөнийг хамруулсан бөгөөд талбайн хүрээнд гадаргын хэбэр аараг толгод, гадарга гуу жалга, өргөн нарийн сайр, жижиг дов, хотгор, элсэрхэг дов, довцог олон янзыг хамарч д.т.д 886-2315м өндөрт байрласан. Монгол орны хөрсний ангилалаар борсаарал, бор, цайвар хүрэн, сайрын хөрсний дэд хэв шинжид багтах чулуурхаг, нимгэн , сайргархаг, элсэн, хужирлаг төрлийн хөрснүүд байсан. Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин маш бага, шимт үе давхарга нимгэн (0-30см) хэврэг өрмөнцөр, жижиг бөөмөрхөг болон үйрмэг бүтэцтэй механикийн нөлөөлөлд тэсвэргүй элсний агууламж өндөр байдаг. Хөрсний үе давхарга ихэвчлэн ВВС-С гэсэн дараалалтай. Хөрсний ялзмаг 0.1-1.6% бүх үе карбонатжилттай. Тусгай зориулалтын 288.45км авто замын түх замын бүтээн байгуулалт болон карьер олборлолтын үед шимт хөрсийг зохих зузаанаар буу 10-15 см орчим хуулж түр замын шимт хөрсийг трассын 2 талаар , карьерийн шимт хөрсийг карьерийн хажууд тэгшилж тавьсан.
2	Зам барилгын ажлын үед тэр замаас агаарт тоосжилт үүсэх	Шимт хөрсний ойр орчимд тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Шимт хөрсний овоолгууд	Үйл ажиллагааны турш	Хөрсний судалгаанд замын трассын 1.5км буюу нийтдээ 3-км орчим өргөнийг хамруулсан бөгөөд талбайн хүрээнд гадаргын хэбэр аараг толгод, гадарга гуу жалга, өргөн нарийн сайр, жижиг дов, хотгор, элсэрхэг дов, довцог олон янзыг хамарч д.т.д 886-2315м өндөрт байрласан. Монгол орны хөрсний ангилалаар борсаарал, бор, цайвар хүрэн, сайрын хөрсний дэд хэв шинжид багтах чулуурхаг, нимгэн , сайргархаг, элсэн, хужирлаг төрлийн хөрснүүд байсан. Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин маш бага, шимт үе давхарга нимгэн (0-30см)

					хэврэг өрмөнцөр, жижиг бөөмөрхөг болон үйрмэг бүтэцтэй механикийн нөлөөлөлд тэсвэргүй элсний агууламж өндөр байдаг. Хөрсний үе давхарга ихэвчлэн BBC-C гэсэн дараалалтай. Хөрсний ялзмаг 0.1-1.6% бүх үе карбонатжилттай. Тусгай зориулалтын 288.45км авто замын тух замын бүтээн байгуулалт болон карьер олборлолтын үед шимт хөрсийг зохих зуаанаар буву 10-15 см орчим хуулж түр замын шимт хөрсийг трассын 2 талаар , карьерийн шимт хөрсийг карьерийн хажууд тэгшилж тавьсан.
3		Авто замын бүтээн байгуулалтын үед машин техник, тоног төхөөрөмжөөс шатах тослох материал асгарахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих, асгаралт болсон тохиолдолд авах арга хэмжээний дотоод журмыг боловсруулах	Төслийн талбай	Эхний жил дотоод журмыг боловсруулан, цаашид дагаж мөрдөх	Сэкер ресорсус монголиа нь 2024 онд асгаралтын журамыг боловсруулсан бөгөөд журамыг нийт үйл ажиллагаа явуулж буй гүйцэтгэгч нар хүргүүлсэн бөгөд гүйцэтгэгч нар дагаж мөрдөхөөс гадна өөрсдөө дотоод журам боловсруулж ажилласан. Нөгөөтэйгүүр гүйцэтгэгч нарт асгаралт үүсэн тохиолдолд хэрхэн арилгах арга хэмжээ авах талаар сургалт орсон.
4		Асгаралтын үед шуурхай арга хэмжээ авах, асгаралтын иж бүрдлийг авто замын барилгын бүсэд асгаралт гарч болзошгүй газруудад байрлуулах	Зогсоолууд, Ажилчдын түр кемп	хөдөөлгөөн хийгдэж байгаа тохиолдол бүрд	Авто замын ажил гүйцэтгэж буй гүйцэтгэгч нар гарын доорх материалыг аюултай хог хаягдлын түр цэгт байршуулах болон зогсоол дээр байршуулсан байна.
5		Химийн бодис материалыг холбогдох журам болон хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу тээвэрлэлт, хадгалалтын нөхцөлийг нарийн баримтлан ажиллах	Түр зам	Үйл ажиллагааны турш	2025 онп ямар нэгэн химийн бодис ашиглагдаагүй бөгөөд ашигласан тохиолдолд Элемент ХХК-тай байгуулсан гэрээнийхээ дагуу хариу арга хэмжээг авч ажиллана.
6	Зам барилгын үйл ажиллагаанаас агаарт	Зориулалтын бус талбайд хог хаягдал хаяж хөрс бохирдуулахаас урьдчилан	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны турш	Шинэжинст суманд замын барилгын ажил гүйцэтгэж байгаа гүйцэтгэгч нар энгийн хог хаягдал устгах, цуглуулах тээвэрлэх зориулалттай Нандин говь ХХК-д,

тоосжилт үүсэх	сэргийлэх, хог хаягдлын дотоод журмыг боловсруулан ажиллах. Энгийн ба аюултай хог хаягдлыг зохих журмын дагуу эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, хадгалан, хог хаягдлыг эрх бүхий байгууллагаар тогтмол ачиж тээвэрлүүлэх.		Гурвантэс сумын барилгын ажил гүйцэтгэж байгаа гүйцэтгэгч нар Шугтаа Уул ОНӨААТҮГ-т энгийн болон шингэн хог хаягдлын гэрээг байгуулсан. Харин аюултай хог хаягдлыг захиалагч тал нь Элемент ХХК-тай гэрэ байгуулсанаас гадна Алтан оршихуй групп ХХК гэрээг байгуулсан. Хог хаягдал ялган ангилах савыг бэлтгэж ангилан ялгаж байна.
-------------------	--	--	--

5.8 Хөрсний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

5.8.1 Шимт хөрсний хадгалалт, хэлбэржүүлэлт ба тэмдэг тэмдэглэгээ



Зураг 11 Талын нөмөр



Зураг 12 Тэргүүн жинст



Зураг 13 Өсөх урам ХХК



Зураг 14 Уужим харгуй



Зураг 15 К238+300 карьер шимт хөрс




К240+800 карьер шимт хөрс

5.8.2 Авто замын бүтээн байгуулалтын үед машин техникээс шатах тослох материал асгарах тохиолдолд авах арга хэмжээ

Гүйцэтгэг нарын талбайд буух үед талбайн зааварчилгааг хүргүүлж генератор, болон засвар үйлчилгээ хийх зогсоол, ШТС-ийн доор шатах тослох материал асгарахаас сэргийлж хамгаалалт


дэсвэх зааварчилгааг өгсөн. Заримт тохиолдолд газрын хэвийнгээс хамаарч ШТС-ийн суурийн хэсгийг шороогоор өндөрлөж хийж өгсөн.

Зураг 16 Талын нөмөр ШТС-ийн хамгаалалтын дэвсгэр дэвсэж буй байдал



Зураг 17 Тэргүүн жинст ХХК-засвар хэсэг болон генераторын талбайн хэсэг





Зураг 18 Чайна рейлвэй ферст гурпн монголиа ХХК ШТС, генератор талбай



Зураг 19 Арвижих алтанговь ХХК ШТС хамгаалалт

5.8.3 Усан орчин төлөвлөгөөний хэрэгжилт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж, хугацаа	Биелэлт
1	Авто зам байгуулах төслийн хүрээнд ажилчдын унд ахуй, замын барилгын ажил, тоосжилт дарах үйл ажиллагаанд нийт 4.1л/с ус ашиглана.	Ашиглах усны хэмжээгээр ус ашиглах гэрээ байгуулан, ус ашиглах болон хаягдал усны дүгнэлтийг жил бүр гаргуулан ажиллах.	Төслийн талбай	Үйл ажиллагааны турш	Усны газрын Е-2504000174 дугаартай ус ашиглах дүгнэлтийн алтайн өвөр говийн сав газраар гаргуулж, гүйцэтгэгч бүр шингэн хог хаягдлын гэрээг холбогдох байгууллагатай байгуулж, тээвэрлүүлэх арга хэмжээг авсан.
2	Зам барилгын ажлын үед тэр замаас агаарт тоосжилт үүсэх	Ус ашиглах гэрээ, боломжит нөөцийн дүгнэлтэд заасан ашиглах хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх тухай үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, усыг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар ашиглах зарчим боловсруулж даган мөрдөж ажиллах.	Төслийн талбай	Үйл ажиллагааны турш	Ашигласан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүйн тул баталгаажусан тоолуур тавьж, түүрийг бүртгэлжүүлж баталгаажуулан нөгөөтэйгүүр усны ариг гамтай хэрэглэх сургалтыг ний ажилчдад суртчилан таниулсан.
3		Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах бөгөөд шугам хоолой бүрийн тоолуурын баталгаажуулалт, түүний хяналтыг хийх	Төслийн талбай	Үйл ажиллагааны турш	Авто замын барилгын ажилд ашиглагдаж байгаа худгууд дээрээ баталгаажсан тоолуурыг суурилуулсан. Сар бүрийн 25-нд тоолуурын хяналтыг хийж заалтыг баталгаажуулдаг

4		Усны хэрэглээг бууруулах, ариг гамтай ашиглах талаар төслийн болон гэрээт нийт ажилчдад сургалт зохион байгуулж, хэрэгжилтийг хянах.	Зогсоолууд, Ажилчдын түр кемп	Жилд 1 удаа	Усны хэрэглээ ариг гамтай, хэрэглэх ус ашиглалтын талаар сургалтыг гүйцэтгэгч нар нийт ажилчиддаа орсон
5		Химийн бодис материалыг холбогдох журам болон хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу тээвэрлэлт, хадгалалтын нөхцөлийг нарийн баримтлан ажиллах	Түр зам	Үйл ажиллагааны турш	Одоогоор химийн бодисын ашиглалт байхгүй
6	Зам барилгын үйл ажиллагаанаас агаарт тоосжилт үүсэх	Төслийн талбайн хэмжээнд байрлах уст цэгүүдээс дээж авч тогтмол шинжилгээ хийлгэх, хүлцэх хэмжээнээс давсан тохиолдолд эх үүсвэр, шалтгааныг тодорхойлж бууруулах арга хэмжээг авах	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны турш	Зам барилгын ажилд ашиглаж байгаа худгуудаас усны шинжилгээ авсан. Шинэжинст суманд байрлах

Ус ашиглах дүгнэлт болон гэрээ

Ewater.mn цахим системээр хүсэлтийг илгээж хүсэлтийн дагуу хянан баталж 2025 оны 4-н сард Авто замын барилгын ажилд ашиглагдах ус ашиглах дүгнэтийг нийслэлийн Усны газар баталгаажуулан гаргасан. Алтайн өвөр говийн сав

газрын захиргаатай ус ашиглах гэрээг 2025 оны 05 сард байгуулж гэрээнд заасны дагуу ашиглаж буй худаг бүрт баталгаажсан тоолуурыг суурилуулж, баталгаажуулалт хийн ажиллаж байна.

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

Улаанбаатар хот Утас: 265528, 265578
Дугаар E-2504-000174

Онцгой гэрээний өдөр: 2025.05.04

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

Онцгой нэр: Сэкер рессорсус монголиа ГХЮ-тай ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 2852468
Регистрийн дугаар: 2852468
Захирал: Баттуул
Холбоо барих дугаар: 11330828
Факс:
И-мэйл хаяг:

2. Төслийн нэр байршил

Төслийн нэр: Баянхонгор аймгийн Шинэжинст сумын "Хотгор"-ын уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км авто замын төсөл
Байршил: Өмнөговь, Гурвантэс, 1-р баг, Гойот
Харьяалагдах сав газар: Алтайн өвөр говийн сав газар
Хямаарах салбар: Авто зам
Төслийн дэлгэрэнгүй: Автозам нь БНБД 32-01-07 "Автозам төсөлөө стандарт"-ын дагуу III зэргийн замын шаардлагыг хангасан 2 талдаа 2 м өргөн хайргын хөвөө, ирмэгээрээ 0.5 м өргөн хучилттай зуравсгал, 7 м-ийн өргөн зорих хэсэгтэй, 2 эгнээ замыг барина.

3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр
Сэкер рессорсус монголиа

4. Ажиллах горим, хүчин чадал

Үргэлжлэх хугацаа	Ажиллах горим	Жилд ажиллах хоног	Хоногт ажиллах ажилчдын тоо	Хоногт ажиллах цаг
2	1 ээлжээр	240	809	12

5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

БАТЛАВ
АЛТАЙН ӨВӨР ГОВИЙН САВ ГАЗРЫН ЗАХИРСАЙНЫ ДАРГА
Б. ПҮРЭВТҮЛГА
2025 оны 05 сарын 14-ний өдөр

БАТЛАВ
"СЭКЕР РЕССОРСУС МОНГОЛИА" ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Б. БАТТУУЛ
2025 оны 05 сарын 14-ний өдөр
Даланзадгад хот

УС АШИГЛАХ ГЭРЭЭ
2025.05.04
Дугаар 25/04

Нэг. Ерөнхий зүйл
Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн Газрын Харилцаагчид Алтгалт Усны газрын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн E-2406-000051 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Алтайн өвөр говийн сав газрын захиргааны 2025 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн А/19 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Нэг талаас: Ус ашиглуулагчийг төлөөлж "Алтайн өвөр говийн сав газрын захиргаа"-ны усны чанар экологи төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн П.Оюунцагт;

Нөгөө талаас: Ус ашиглагчийг төлөөлж : Баянхонгор аймаг, Шинэжинст сумын хотгорын уурхай утас: 89966311, улсын бүртгэлийн дугаар: 9019097451, регистрийн дугаар: 2852468, "Сэкер рессорсус монголиа" ХХК-ны байгаль орчны мэргэжилтэн Б.Мадагбадам нар ус ашиглах талаар тохиролцсон энэхүү гэрээ 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл энэхүү гэрээг байгуулах.

Ус ашиглагч нь ус ашиглах гэрээ байгуулах тэмдгийн хураамж 100,000 /Нэг зуун мянган/ төгрөгийг тус Өмнөговь аймгийн төрийн салхийн дансанд тушаах.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт:

- Хайргын хөвөө байгуулахад ашиглах усны хэмжээ
- Зам усалгаанд ашиглах усны хэмжээ
- Цементбетон хучлага хийхэд ашиглах усны хэмжээ
- Зөөврийн шороогоор далан байгуулахад ашиглах усны хэмжээ
- Далангийн үл хөрс услахад ашиглах усны хэмжээ
- Ашиг олох зориулалтаар ахуйн, үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглах усны хэмжээ
- Бутасан чулууны суурь байгуулахад ашиглах усны хэмжээ
- Хөлдөлтөөс хамгаалах үс бэлдэхэд ашиглах усны хэмжээ
- Цементээр бэхжүүлсэн суурь хийхэд ашиглах усны хэмжээ
- Асфальтанбетон хольцоор хучилт хийхэд ашиглах усны хэмжээ

2.2. Ашиглах усны хэмжээ:

- Хайргын хөвөө байгуулахад ашиглах усны хэмжээ- 22,477.06м³
- Зам усалгаанд ашиглах усны хэмжээ- 4,608.00м³
- Цементбетон хучлага хийхэд ашиглах усны хэмжээ- 7,914.07м³
- Зөөврийн шороогоор далан байгуулахад ашиглах усны хэмжээ- 33,846.48м³
- Далангийн үл хөрс услахад ашиглах усны хэмжээ- 172,800.00м³
- Ашиг олох зориулалтаар ахуйн, үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглах усны хэмжээ- 15,532.80м³

Зураг 20 Ус ашиглах гэрээ болон дүгнэлт

ӨМНӨГОВЬ АЙМАГ БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 101 тоот, 3 дугаар баг, Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46053
Утас: (976) 7053 2148, Цахим шуудан: ombogaj@gmail.com

Танай: 2024.11.05 № 196

Цооног өрөмдөх зөвшөөрөл олгох тухай

"Сэкер рессорсус монголиа" ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших "Хотгор"-ын чулуун нүүрсний уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км авто зам барихаар Зам, тээвэр барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 16 дугаар тушаалаар авто замын чиглэлийг баталж, Зам тээврийн яамтай 2024 оны 382 дугаартай "Тусгай зориулалтын авто зам барих, ашиглах гэрээ"-г байгуулсан бөгөөд зам засвар ашиглах 15 цооног өрөмдөх зөвшөөрөл авах хүсэлт ирүүлсэн байна.

Дээрх хүсэлтийг хянан Монгол Улсын "Усны тухай хууль"-ийн 27 дугаар зүйлийн 27.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн авто зам засварын зориулалтаар хавсралтад заасан цэгүүдэд цооног өрөмдөх зөвшөөрлийг дараах нөхцөлтэйгөөр олгож байна.

Үнд:



1. "Усны тухай хууль"-ийн 21 дүгээр зүйлд заасны дагуу Усны мэргэжлийн байгууллагаар өрөмдүүлэх
2. Худаг өрөмдөх явцад байгаль орчныг бохирдуулахгүй байх, ажил дууссаны дараа тухайн талбайд нөхөн сэргээлт хийх
3. Өрөмдөмөл худгийн паспортыг манай газраас авч мэргэжлийн байгууллагаар үнэн зөв бичилт хийлгэн ирүүлж баталгаажуулах
4. Ус ашиглагч бусдад зөвшөөрөлгүйгээр ус зарж борлуулах, ашиглалтын зориулалтыг өөрчлөхийг хориглоно.
5. Усыг ашиглах боломжит нооцийн дүгнэлт гаргуулж, үр ашигтай, хэмнэлттэй ашиглах
6. Усны тухай хуулийн 28.4 дэх заалтыг үндэслэн ус ашиглуулах дүгнэлт гаргуулах

Мөн Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутаг дэвсгэр дээр байгаа 1. 44° 34' 26.37" 99° 17' 28.95" 2. 44° 29' 17.31" 99° 19' 57.46" 3. 44° 29' 21.9" 99° 24' 59.8" 4. 44° 9' 23.2" 99° 41' 44.92" цэгүүд цооног өрөмдөх зөвшөөрөл олгох боломж болохыг үүгээр мэдэгдье.

Цооног өрөмдөх газрын нэр, солбицол

№	Сумын нэр	Зориулалт	Солбицол
1			43° 58' 56.43" 99° 53' 17.52"
2			43° 49' 34.29" 100° 4' 42.89"
3			43° 47' 28.18" 100° 7' 22.69"
4			43° 36' 37.33" 100° 8' 40.1"
5			43° 33' 18.27" 100° 11' 24.58"
6	Гурвантэс	Авто зам засвар	43° 27' 41.73" 100° 27' 22.58"
7			43° 25' 55.33" 100° 54' 8.61"
8			43° 16' 5.05" 101° 4' 50.3"
9			43° 7' 37.87" 101° 6' 49.34"
10			43° 4' 40.04" 101° 19' 58.16"
11			42° 59' 34.18" 101° 20' 17.62"

Зураг 21 Өмнөговь аймгийн Байгаль орчны газрын цооног өрөмдөх зөвшөөрөл




Зураг 22 Баянхонгор аймгийн байгаль орчны газрын цооног өрөмдөх зөвшөөрөл

Усыг гэрээний дагуу ашиглаж , хяналт тавьсан байдал

Шинэжинст сумын нутагт одоогоор 4-н худаг, Гурвантэс сумын нутагт 13 худгийг авто замын барилгын ажилд ашиглаж байна. Ашигласанаас хойш тоолуурын

баталгаажуулалтыг сумдын холбогдох мэргэжилтэнүүдээр баталгаажуулан ус ашиглах гэрээнд заасан хэмжээгээр ашиглаж байна.



Зураг 23 Тоолуур баталгаажуулсан акт




Зураг 26 Цооног өрөмдөх, усны барилга байгууламж арих, сэргээн засварлах аж ахуй нэгийн тусгай зөвшөөрөл


Усныг ариг гамтай хэрэглэх ашиглах

Усаа хэмнэх зар сурталчилгааны постерыг ажилчдын нүдэнд харагдахуйц газар байрлуулав. өглөө бүрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааны үед мэдээлэл өгч ажиллахаас гадны усны зохистой хэрэглээний, байгаль

орчныг хамгаалах талаар нийт ажилчдын сургалтын удирдамж гаргаж, гүйцэтгэгч компанийн байгаль орчин тус бүр ажилчдаа сургалт орсон.





Зураг 27 Усны хэрэглээний мэдээлэх постер болон сургалт орж буй байдал



Зураг 28 Сургалтын сэдэв РРТ агуулга

Усны шинжилгээ

Ашиглаж буй усны шинж чанарыг авч тодорхойлсон бөгөөд чанарын үзүүлэлтын хувьд Ca Mg агууламж өндөр байх хэдий ч говийн бүсийн гүний усны шинж чанарыг илэрхийлж байсан. Усны ерөнхий химийн шинэжилгээг усны итгэмжлэгдсэн лабортораориор хийлгэсэн болно.



Зураг 29 Шинэжинст сумын нутагт орших худгийн усны шинэжилгээ



Зураг 30 Зураг 29 Гурвантэс сумын нутагт орших худгийн усны шинэжилгээ



5.9 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж, хугацаа	Биелэлт
1	Төслийн үйл ажиллагаагаар 724 га талбай эвдрэлд өртөж, шимт хөрсийг хуулснаар ургамлын нөмрөг устгах	Авто замын ажлын ерөнхий төлөвлөгөө, зураг төслийн дагуу гүйцэтгэх, төлөвлөлтийн бус газар хөндөхгүй байх (тэмдэг тэмдэглээ байршуулах).	Төслийн талбай	Үйл ажиллагааны турш	Сэкер ресурс ХХК-ийн газар хөндөх тухай журам дагаж мөрдөхөөс гадна гүйцэтгэгч нарт батлагдсан маршрутын дагуу зорчих тээвэрлэлт хийж, хориглосон тэмдэг тэмдэглэгээг байршуулсан
2	Машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдан шатах тослох материал асгарсны улмаас ургамлын бүрхэвч бохирдож болзошгүй.	Замын ажилчдад төсөлд тусгасан зам харгүйгээс бусад газраар машин техник хэрэгслээр явж ургамлан нөмрөг доройтуулахгүй байх талаар анхааруулга сануулга өгөх, МУ-ын улаан ном, Бүс нутгийн болон олон улсын улаан дансанд бүртгэлтэй, олон улсын гэрээ, конвенцоор хамгаалагдсан ховор, нэн ховор ургамлын талаарх мэдээллийг нийт ажилтан, гэрээтүүд болон нутгийн иргэдэд мэдээлж, хамгааллын талаар сургалт, сургалчилгаа хийж байх	Төслийн талбай	Үйл ажиллагааны турш	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ болон, орчны хяналт шинэжилгээний хүрээнд бүс нутгийн ургамлан нөмрөгийн судалгааг хийлгэсэн бөгөөд тус судалгаагаар тогтоогдсон ховор, нэн ховор ургамлын талаарх сургалтыг гэрээт компаниудын байгаль орчин инженерүүдийн ажилчдад орсон бөгөөд нийт ажилчдад сургалтыг орсон.

Ургамал болон амьтны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Түр замын дагуу олон салаа зам гаргах батлагдсан маршрутын дагуу явахын тэмдэг тэмдэглэгээг байршуулах нь ургамлан нөмрөг иүүтэйгээр талхагдахаас урьдчилан сэргийнэ.



Зураг 31 Хориглох тэмдэгийг тавьсанаар зөвхөн маршрутын дагуу зорих




Зураг 32 Түр зам дагуу байршуулсан тэмдэг тэмдэглэгээ

Зарим нэн ховор, ховор ургамлын экологи эдийн засгийн үнэлгээ

№	Зүйлийн монгол нэр	Зүйлийн латин нэр	Үнэлгээ	
			Хуурай жин кг/төг	Нойтон жин кг/төг
1	Цэлийн аргамжинцэцэг (Цагаан гоёо)	<i>Cistanche deserticola</i> Ma	60900	31700
2	Хулан (Монгол) хойрго	<i>Potaninia mongolica</i> Maxim.	161600	103500
3	Потанины хотир	<i>Zygophyllum potaninii</i> Maxim.	232800	149000
4	Потанины улаантулам	<i>Incarvillea potaninii</i> Batal.	171500	109800
5	Зүүнгарын гоёо (Улаан гоёо)	<i>Cynomorium songaricum</i> Rupr.	123000	78700
6	Грубовын ортууз	<i>Oxytropis grubovii</i> Ulzj. (= <i>Spongiocarpella grubovii</i>)	98100	58900
7	Муркрофтын жигд	<i>Elaeagnus moorcroftii</i> Wall. ex Schlecht. (= <i>E. angustifolia</i>)	90200	36100
8	Федченкогийн зээргэнэ	<i>Ephedra fedtschenkoae</i> Pauls.	152600	97700
9	Намхан гишүүнэ	<i>Rheum nanum</i> Sievers	108700	69600
10	Монгол бүйлэс	<i>Amygdalus mongolica</i> Ricker	171000	109400

Зураг 33 Сургалтаар ургамлын үнэлгээний талаар таницуулсан хэсэг

Говийн зарим ховор ургамал



ИХ БОГД УУЛЫН НЭН ХОВОР, ХОВОР УРГАМАЛ

ХААИС-ийн судалгааны багийн 2015 оны судалгаагаар Их Богд уулын БЦГ-т нийт **52 овог 225 төрөл, 465 зүйл ургамал** бүртгэгдсэн байдаг. Үүнд:

1. 14 овогт багтах 24 төрлийн **25 зүйл нэн ховор ургамал**
2. 23 овогт багтах 33 төрлийн **39 зүйл төрөл ховор ургамал**
3. **61 зүйл Төв Азийн болон Монголын унаган /эндемик/**

 <i>Алтаанзнуур мүүз</i> <i>Rhodiola rosea</i>	 <i>Вансэмбэрүү банздоо</i> <i>Saussurea involucrata</i>	 <i>Нангиад зээрэнэ</i> <i>Ephedra sinica</i>	 <i>Барилдт буйлс</i> <i>Amygdalus pedunculata</i>	 <i>Ахар нэвчит хунчир</i> <i>Astragalus scaberulus</i>	 <i>Нуцсан намуу</i> <i>Papaver rhoeas</i>
 <i>Алтайн жамьянмлаа</i> <i>Troilus asiaticus</i>	 <i>Алтайн сонгию</i> <i>Allium altaicum</i>	 <i>Хонин ари</i> <i>Juniperus sabina</i>	 <i>Шивүүр ортууз</i> <i>Oxytropis asanthasea</i>	 <i>Шивүүрт жав</i> <i>Acanthophilum</i>	 <i>Прайсн зохимон</i> <i>Senecio jricei</i>
 <i>Төв-азийн лагай</i> <i>Asterothamnus</i>	 <i>Монгол буурцаана</i> <i>Chesneya mongolica</i>	 <i>Монгол мөнххарвана</i> <i>Mongolicus</i>	 <i>Сөдхэй аичээнэ</i> <i>Potentilla sanguisorba</i>	 <i>Торсон аичээнэ</i> <i>Potentilla sericea</i>	 <i>Сөвөөн зовдор өвс</i> <i>Clematis fruticosa</i>

Зураг 34 Баянхонгор аймгийн их богд уулын нэн ховор, ховор ургамал



Зураг 35 Сургалт орж буй байдал

Гүйцэтгэгч нарын байгаль орчны мэргэжилтэнүүд өдөр бүрийн наряд болон сургалтын хуваарьт өдрөө ургамлын талаарх мэдлэг олгох сургалтыг зохион байгуулдаг.


5.10 Амьтны аймаг үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж, хугацаа	Биелэлт	
Түүхий эдийн олборлолтод өртөх талбайн хэмжээгээр биологийн олон янз байдлын амьдрах орчин доройтох, амьдрах орчноосоо дайжих 288.45км автозам нь зэрлэг амьтдын амьдрах орчныг торойтуулах, хуваагдал үүсэх	Төслийн үйл ажиллагаагаар 724 га талбай эвдрэлд өртөж, шимт хөрсийг хуулснаар ургамлын нөмрөг устах	Элс, хайрга, чулуу олборлох карьерын нүх, хонхор зэргийг ашиглаж дууссан даруйд бөглөх	Карьерууд	Үйл ажиллагааны турш	Зөвшөөрөл авсан карьеруудынхаа техникийн нөхөн сэргээлтийг хийж нөхөн сэргээлт хүлээн авах комисст нөхөн сэргээлтийг хүлээлгэн өгнө. Одоогоор ашиглаж дууссан карьер байхгүй байгаа болно.	
	Машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдан шатах тослох материал асгарсны улмаас ургамлын бүрхэвч бохирдож болзошгүй.	Зуд болон ган гачигтай үед зэрлэг ан амьтдад өвс, тавьж ойр орчмын ан амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Төслийн талбайн ойр орчимд	Төслийн талбайн ойр орчимд	Үйл ажиллагааны турш	Өвөлжилт хүндэсэн нөхцөлд зэрэг ан амьтанд өвс тавьж өгөх биотехникийн арга хэмжээний хүрээнд 1000 боодол ногоон тэжээл авсан бөгөөд өвөлжилт хүндэрсэн үед тараах ажлыг холбогдох албан тушаалтаны хамт тухайн нөхцөл байдалд тодорхойлсон байршилд тараахаар бэлтгэл ажлыг хангаад байна.
	Ажилчдын хууль бус ан агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад хяналт тавих, сургалт ухуулга явуулах, ан амьтан агнасан тохиолдолд хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх.	Төслийн ажилчид	Төслийн талбайн ойр орчимд	Төслийн талбайн ойр орчимд	Үйл ажиллагааны турш	Байгаль орны төлөв байдлын үнэлгээ, орчны хяналт шинэжилгээний хөтөлбөрийн хүрээнд судлагдсан амьтны талаар мөн хууль бус ан агнуур хийхгүй байх талаар нийт ажилчдын сургалтыг зохион байгуулж, агнуур гаргасан тохиолдолд хариуцлага тооцох хуулийн механизмын талаарх мэдээллийг өгсөн. Нөгөөтэйгүүр зам харуугаас гарч амьтдыг үргэх, хурц гэрэл тусгаж амьтдыг үргэх, гэрэлийн тусгал амьтанд ямар нөлөө үзүүлдэг талаарх сургалтыг нийт тусан гүйцэтгэгч компани хүмүүст орсон.
	Замын ажилчдад төсөлд тусгасан зам харгүйдгээс бусад газраар машин техник хэрэгслээр явж ойр орчмын амьтдыг үргээхгүй байх талаар сануулга өгөх, ан амьтны талаарх мэдээллийг нийт ажилтан, гэрээтүүдэд мэдээлж, хамгааллын талаар сургалт, сурталчилгаа хийх	Төслийн ажилчид	Төслийн талбайн ойр орчимд	Төслийн талбайн ойр орчимд	Үйл ажиллагааны турш	

Биотехникийн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2025 оны БОМТөлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ган гачиг, зуд болох үед Шинэжинст сумын Сэгс цагаан богд уул болон Говь Гурвансайхан байгалийн цогцолборт газар, Тос тосон бумбын байгалийн нөөц газрын зэрлэг ан н амьтдад өвс тавьж өгөх зорилгоор 1000 боодол ногоон өвсийг

Далай шим эргэлт ХХК-аас худалтыг хийж, цаг хүндэрсэн үед сумдын байгаль хамгаалагч тусгай хамгаалалттай газрын захиргаатай хамтран тодорхойлогдсон газарт байршуулахаар ярилцсан бөгөөд одоо тавих нь тохиромжгүй байгаа билээ.



Зураг 36 Ногоон өвсийг тоолон хүлээж авч буй байдал

Зэрлэг ан амьтны талаарх сургалт

Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг буурлах зорилтын хүрээнд авто замын трассын дагуу ямар зэрлэг ан амьтан нутагладаг тэгээрийг хэрхэн таних, зэрлэг ан амьтны хууль бус ан агнуур хийсэн тохиолдолд хэр хэмжээний торгууль ноогдуулдаг талаарх мэдлэг олгох сургалтыг манай компани Тос тосон бумбын байгалийн нөөц газартай хамтран ажиллаж нийт гэрээт компаниудын зэрлэг ан амьтны талаарх сургалтыг Гурвантэс суманд зохион байгуулсан.

Мөн Дэлхийн ирвэс хамгаалах өдрөөр Их богдын уулын тусгай хамгаалалттай газрын захиргаатай хамтран, Тос тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын захиргаатай хамтран “Гэрлийн бохирдол” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулж нийт ажилчидад танилцуулж, сургуулийн насны хүүхдүүд танин мэдэхгүйн мэдлэг олгох сургалтыг хамтран зохион байгуулсан билээ.



Зураг 37 Гэрлийн бохирдол сэдэвт сургалт



Зураг 38 Сургалт орж буй үйл явц

5.11 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт

Орчны тохижилт ажил-1

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын болон Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт хийгдэж буй авто зам барилгын ажил явцад орчны тохижилт, нөхөн сэргээлтийн хүрээнд Шинэжинст болон Гурвантэс сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор тус бүр 500ш шар хуайс, хайлаас модыг салхины хаалт, хашаажуулалтын зорилгоор тариалсан. Тариалахдаа хөрсний шимт чанарыг сайжруулах зорилгоор NPK иж бүрдэл(азот, кали, фосфор) –

агууламжтай бордоог 15:15:15 харьцаатайгаар хөрсөнд уусгаж бордож тариалалтыг хийсэн. Модны тарьц суулгацын нийлүүлэлтийг орон нутгийн ойн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагаас худалдан авсан.

Мөн мод усалгааны хуваарь гаргасанаар гүйцэтгэгч компаниуд маань хуваарын дагуу усалгааг 9-н сар хүртэл хийсэн.

Хүснэгт 6 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн хэрэгжилт

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Суулгацын тоо/ш/	Хэрэгжилт
Орчны тохижилт, нөхөн сэргээлт					
1	Тэрбум хөдөлгөөний хүрээнд мод тарих	ӨМА-н мод тарих зардлыг шийдвэрлэх- Ханхонгор сум	Орчны тохижилт	500	Өмнөговь аймаг нь Ханхонгор сумын эвдэгдсэн 50га талбайн нөхөн сэргээлт хийх ажлын хүрээнд тус талбайд 500ш модны тариалалтыг хийсэн.
2		Шинэжинст сумын төв		500	Шинэжинст сумын ногоон байгууламжыг нэмэгдүүлэх зорилгоор сумын төвийн ногоон байгууламжид 3-н настай шар хуайс, хайлаас модыг тариалсан.



Зураг 39 Модны суулгац, усалгаа, ургалтын төлөв байдал

SAKER RESOURCES MONGOLIA **МОД УСАЛГААНЫ ХУВААРЬ** 2025 он 05 сар

Огноо	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30
5-сар																														
6-сар																														
7-сар																														
8-сар																														
7-сар																														
8-сар																														
9-сар																														

Хуваарь боловруулж баталсан : *[Signature]* Б.Мядагбадам
СРМ-БОМ Эргэжилтэн



5.12 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутаг дахь Хотгорын нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийг Гурвантэс сумын Шивээ хүрэнгийн бооит хүртэл тавигдах авто замын төслийн хүрээнд археологийн авран хамгаалах малтлага судалгааг 2019 онд Шинжлэх ухааны академийн археологийн хүрээлэн хийж гүйцэтгэсэн бөгөөд авто замын хамаарлын бүсэд 13 археологийн дурсгалыг амжилттай малтан судласан. Эдгээрээс 11 дурсгал Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт, 2 дурсгал Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт багтсан. Үүнд хүрэл зэвсгийн үед холбогдох сагсай хэлбэрийн булш 1(5-р дурсгал), оршуулгын дурсгалд холбогдох тахил тайлгын байгууламж 10(1,2,4,6,7,8,9,11, 13-р дурсгал) хүний гараар бүтсэн чулуун байгууламж 2(10,12-р дурсгал) тус тус багтаж байна. Үүнээс 6-н тахилгын байгууламж (1,2,4,6,8,9), 2 дурсгал булш(3,7)- р дурсгалыг тонуулчид тоносон сүйтгэсэн болохыг тогтоосон. “Сагсай хэлбэрийн булш” хэмээн нэрлэгдсэн хүрэл зэвсгийн үед холбогдох хөндөгдөж тоногдоогүй 1 булшийг (5-р дурсгал)-аас (Зураг-2,3,4) эртний хүний хадгалалт сайтай бүтэн яс илэрч олдсон тухайн

үеийн олог талын мэдээллийг өгөх эрдэм шинжилгээний чухал ач холбогдолтой олдвор болсон. Ийм хэлбэрийн булш нь тархалтын хувьд урд захын дурсгал болж буйгаараа шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой юм. Ингээд тус дурсгалыг авран хамгаалах арга хэмжээг авсан.

Мөн энэхүү судалгааны зэрэгцээ Шинэжинст сумын уугуул, Гурван-Эрдэнэ багшийн дээд сургуулийн Түүх, нийгэм судлалын 2 курсын оюутан Э.Хатанбаатар, тус сумын байгаль хамгаалагч Н.Мөнхдалай нарын мэдээллийн дагуу тус сумын нутагт орших Хан-Уул, Цагаан хаалга хэмжээх газарт илэрсэн тоногдсон хадны оршуулгыг үзэж шалган олдвор хэрэглэгдэхүүнийг ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт хүлээлгэсэн өгсөн (Зураг-5,6,7). Ийнхүү анх удаа Шинэжинст сумын нутгаас хадны оршуулга илэрсэн тохиолдол болсоноороо онцлог юм.

Харин төслийн талбайн палеонтологийн нөөц баялгийн үнэлгээг 2023 онд Шинжлэх ухааны академийн палеонтологийн хүрээлэн хийж гүйцэтгэсэн бөгөөд хээрийн тандан судалгааны ажлыг зам барих зурвас болон

нөлөөллийн бүсийг 5-7км-ийн зайтай талбайд гүйцэтгэсэн.


Замын болон карьер олборлолтын үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн дурсгал, олдвор санамсаргүй байдлаар олдсон

тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т заасны дагуу ажлаа зогсоож, энэ тухай сумын Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэж, арга хэмжээ авна.


4.3. Малтан шинжилсэн дурсгалуудын товч мэдээлэл

№	Дурсгалын дугаар	Дурсгалын төрөл	Холбогдох он цаг	Хэмжээ (см)	Олдвор хэрэглэгдэхүүн	Байршил
Баянхонгор аймгийн Шинэжинст сум						
1	Дурсгал 1	Тахилгын байгууламж	Хүрэл зэвсгийн үе	125 x 95	-	N 44° 34' 12.2" E 99° 17' 25.5"
2	Дурсгал 2	Тахилгын байгууламж	Хүрэл зэвсгийн үе	120 x 135	-	N 44° 34' 12.3" E 99° 17' 25.8"
3	Дурсгал 3	Булш	Хүрэл зэвсгийн үе	380 x 232	Хүн, малын ясны хугархай	N 44° 34' 12.0" E 99° 17' 26.1"
4	Дурсгал 4	Тахилгын байгууламж	Хүрэл зэвсгийн үе	110 x 62	-	N 44° 34' 11.8" E 99° 17' 26.7"
5	Дурсгал 5	Булш	Хүрэл зэвсгийн үе	790	Хүний яс	N 44° 24' 48.1" E 99° 24' 19.7"
6	Дурсгал 6	Тахилгын байгууламж	Хүрэл зэвсгийн үе	200 x 170	-	N 44° 23' 31.7" E 99° 26' 27.4"
7	Дурсгал 7	Булш	Хүрэл зэвсгийн үе	510 x 480	Шавар ваарны хагархай	N 44° 23' 32.1" E 99° 26' 27.6"
8	Дурсгал 8	Тахилгын байгууламж	Хүрэл зэвсгийн үе	320 x 280	-	N 44° 23' 31.7" E 99° 26' 27.6"
9	Дурсгал 9	Тахилгын байгууламж	Хүрэл зэвсгийн үе	390 x 220	-	N 44° 23' 32.0" E 99° 26' 27.3"
10	Дурсгал 10	Чулуун байгууламж	Тодорхойгүй	170 x 150	-	N 44° 16' 30.4" E 99° 30' 26.1"
11	Дурсгал 11	Тахилгын байгууламж	Тодорхойгүй	300 x 245	Малын яс	N 44° 11' 08.8" E 99° 40' 41.2"
	Хан уул	Хадны оршуулга	Тодорхойгүй	190 x 62	Хүний яс, мод, даавуу эдлэл	N 44° 29' 46.9" E 99° 19' 03.0"
	Цагаан хаалга	Хадны оршуулга	Тодорхойгүй	-	Хүн, малын яс	N 44° 25' 19.3" E 99° 18' 56.1"
Өмнөговь аймгийн Гурвантэс сум						
12	Дурсгал 12	Чулуун байгууламж	Тодорхойгүй	160	-	N 43° 18' 41.6" E 101° 05' 33.5"
13	Дурсгал 13	Тахилгын байгууламж	Хүрэл зэвсгийн үе	220 x 130	Мал, амьтны яс, галын ором	N 43° 02' 51.9" E 101° 18' 35.2"


Зураг 40 Малтан шинжилсэн дурсгалуудын товч мэдээлэл




Зураг 41 Дурсгал-5 малтлага судалгаа



Зураг 42 Дурсгал-5 эртний оршуулга илэрсэн байдал



Зураг 43 Дурсгал-5-с илэрсэн хүний яс



Зураг 44 Цагаан хадны оршуулгын үзлэг судалгаа



Зураг 45 Хан уулын хадны оршуулгаас олдсон даавуун эдлэл




Зураг 46 Хан уулын хадны оршуулгаас илэрсэн модон эдлэл


5.14 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт


Хүснэгт-5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө


№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Биелэлт	Зураг
1	Байгалийн гамшигт үзэгдэл	“Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г боловсруулан, жил бүр сайжруулж мөрдөн ажиллах	Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг туслан гүйцэтгэгч байгууллагууд боловсруулан мөрдөн ажиллаж байна.	

2		<p>Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэргэжлийн байгууллагаар сургалт зохион байгуулуулж, ажилчдыг дадлагажуулах</p>	<p>Гурвантэс сумын гал унтраах ангитай хамтран гамшгийн үеийн бэлэн байдлын талаар сургалт орсон</p>	
3		<p>ОБЕГ-ын мэдээ болон цаг агаарын станцын мэдээг тогтмол хянаж үйл ажиллагаанд харгалзан үзэж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, дохиог хүмүүст дамжуулан анхааруулга өгч байх</p>	<p>Шинэжинст сумын цаг уурын газар болон Гурвантэс сумын цаг уурын албанаас өдөр тутамын цаг агаарын мэдээг авч туслан гүйцэтгэг компаниудад мэдээлэлдэг</p>	

4	Гал түймэр	Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлж төслийн талбайд байршуулах, гал унтраах хэрэгслийн хэвийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт тогтмол хийх	Гүйцэтгэгч компаниуд кемп тус бүрдээ галын сарааг байршуулж, галын хорны үзлэг шалгалтыг хийж бүртгэлжүүлдэг
5		Галын аюулын талаар анхааруулга самбар, аваарын гарц байрлуулах	Гүйцэтгэгч нар оффис болон ШТС галын сараануудад дээрээ галын аюулын анхааруулах самбарыг байршуулсан




				
6	<p>Үйл ажиллагааны осол гэмтэл</p>	<p>Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах</p>	<p>Гүйцэтгэгч нар ажилчиддаа зуны болон өвлийн хувацаг олгосон</p>	
7		<p>Бүх ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх</p>	<p>Урьдчилсан болон өдөр тутамын зааварчилгаа өгч ажил гаргадаг</p>	

				
8	Автомашин ы осол авар	Замын хөдөлгөөний аюулгүйн дүрмийг мөрдүүлж ажиллах	Сэкер ресурс монголиа ХХК-н замын хөдөлгөөний журамыг батлаж гүйцэтгэгч нарт хүргүүлэн мөрдөж ажиллах үүргийг өгсөн.	 <p>Тур замын дагуу тээврийн хэрэгслийн хурдны хязгаарлалт зийх, хурдны хязгаарлалт тогтоох дотоод журам</p> <p>Нэг. Зорилго</p> <p>Энэхүү журмын зорилго нь:</p> <ul style="list-style-type: none"> • Ван барилгын ажил явагдаж буй талбайд хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг хангах • Ажлын талбайн дотор болон саян орчинд хурд хэтрүүлэхээ шалтгаалсан осол, зарчмаас урьдчилан сэргийлэх • Барилгын ажилчдын эхнэ, эрүүд нэгд, тоног төхөөрөмжийг хангаалах • Тур замын явдал гэмтлээс сэргийлж замын ашиглалтын хугацааг уртасгах • Байгалин орчинг бохирдох (тусгаарлагч, чимчгэр, дуу чимч) -ээс урьдчилан сэргийлэх • Ажил гүйцэтгэлийн уялдаа холбоот тасалдуулахгүй, салдгүй үйл ажиллагааг дэмжихэд оршино. <p>Хоёр. Хамрах хүрээ</p> <p>Энэхүү журам нь:</p> <ul style="list-style-type: none"> • Барилдаж буй авто замын талбай, тур зам, шороон болон цементэн суурь бүхий амьс түр, тойрон зуузааруула • Гүйцэтгэгч байгууллагын бүх тээврийн хэрэгсэл, машин механизм • Туслам гүйцэтгэгч болон тээвэрлэлт хариуцсан байгууллагуудын тээврийн хэрэгсэл • Илгөөр, тусгай ажилтнуудын болон захиалагчийн тээврийн хэрэгсэл • Замын орчмын оршин суугчдын тээврийн хэрэгсэл • Буцад түр зорчих иргэд, аж ахуйн илгэний автотээвэр хангаарна. <p>Гурав. Нэр томъёоны тодорхойлолт</p> <ul style="list-style-type: none"> • Тур зам-зан барилгын хугацаанд түр зургадгаар ашиглагдах зөрчих нэгж • Хурдны хязгаар-зориж явдаг төмөр оролцон буй тээврийн хэрэгслийн дээд хурд • Ажлын талбай-зан барил, засварлах, тоног төхөөрөмс суурилуулах бүс нутаг • Жолооч-тээврийн хэрэгслийг жолоодон буй итгэл • Хөдөлгөөний зохицуулалт-хурдны хязгаар, чиглэл, зорчих хугацаанд тавигдан нэмэлт • Химилтийн байгууллага, ажилтан-ХАБЭА болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нэгж <p>Дөрөв. Хурдны хязгаар тогтоол, зохицуулалт</p> <p>4.1 Тур замын явцад байдлаас шалтгаалийн хурд дараах байдлаар тогтоогдоно:</p> <ul style="list-style-type: none"> • Хурд давцан явшин: нөхцөлөө 10-15 км/цаг • Илгээг зарим автохөдөө: 15-20 км/цаг • Хөдөлгөөр эрүүлэгч олноор байрладаг бүс-5-10 км/цаг • Гулгатай, шавартай, харагдах орчин хязгаарлагдсан бүс-5 км/цаг хуртаа <p>4.2 Хурд хэтрүүлэлтийг дараах нөхцөлд нэмэлтээр хязгаарлана:</p>
9	Химийн бодис	Химийн бодисыг хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу хадгалах, тээвэрлэх, ашиглах	Авто зам дээр химийн бодис ашиглагдаагүй болно.	

<p>1 0</p>		<p>Химийн бодис хадгалах, ашиглах үед химийн бодис асгарсан, алдагдсан, гал түймэр гарснаас үүсэж болзошгүй аюул, ослын үед ажиллах дүрэм журмыг боловсруулах, дагаж мөрдөх</p>	<p>Асгаралтын журамыг боловсруулан асгаралт үүссэн тохиолдолд дагаж мөрдөх арга хэмжээг авч ажиллана</p>	
<p>1 1</p>		<p>Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, саармагжуулах асгаралтын иж бүрдлийг бэлэн байлгах</p>	<p>Авто замын үйл ажиллагаанд химийн бодис ашиглаагүй болно</p>	


5.15 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт-6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Ажлын гүйцэтгэл
1. Орчны тохижилт нөхөн сэргээлт				
1	Энгийн хог хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулах зориулалтын тэмдэг тэмдэглэгээтэй хогийн савыг талбайд байршуулах	Үйл ажиллагаа эхлэх үед	Ахуйн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, цуглуулах зориулалтын тэмдэг тэмдэглэгээтэй хогийн цэг байгуулсан. 
2		Ахуйн хатуу хог хаягдлын ангилан ялгах цэг байгуулах	Үйл ажиллагаа эхлэх үед	
3		Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг аймгийн хог хаягдал дахин боловсруулах төсөл хөтөлбөр, үйлдвэрт нийлүүлэх	Жилд 2 удаа	 
4		Бусад хог хаягдлыг гэрээт ААН-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	Тухай бүр	Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын тамгын газартай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, зайлуулах гэрээ байгуулан гэрээний дагуу хог хаягдлыг нийлүүлэх, тээвэрлэх арга хэмжээ авч ажилласан. 
5		Батлагдсан маягт болон “эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, журмаар тогтоосон хугацаанд сумын Засаг даргад хүргүүлэх	Тухай бүр	

Хог хаягдлын тээвэрлэлтийн бүртгэлийг тээвэрлэсэн тухай үедээ тэмдэглэн сумын хогын

6		Төслийн талбай орчмын эргэн тойронд 50 м зайд цэвэрлэгээ хийх	Улиралд 1 удаа	<p>цэгт хүлээлгэн өгч гарийн үсэг зуруулан баталгаажуулсан.</p>   <p>Карьерын болон кемпийн байрлалд 7 хоногт 2-3 удаагийн давтамжтай цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж хэвшсэн.</p>
7	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж эх үүсвэр дээр түр хадгалах цэг байгуулах, төслийн талбайд зориулалтын савыг байрлуулан, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Эхний жилд	    <p>Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж эх үүсвэр дээр түр хадгалах цэг байгуулсан. Төслийн</p>

<p>8</p>	<p>Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, хадгалах шилжүүлэх үйл ажиллагаанд байнгын хяналтыг тавьж, бүртгэл хөтлөх</p>	<p>Сар бүр</p>	<p>талбайд зориулалтын савыг байрлуулан тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.</p>  <p>Техникээс гарсан аюултай хог хаягдлыг ангилан ялгаж байршуулсан саванд хаяж, эмнэлгээс гарсан аюултай хог хаягдлыг Шинэжинст сумын эрүүл мэндийн төвд хүлээлгэн өгч бүртгэлийг хийж байна</p>
<p>9</p>	<p>Хэвийн үйл ажиллагааны үед аюултай хог хаягдалтай харьцах болон аюул ослын үед ажиллах зааварчилгааг түүнтэй харьцдаг ажилтан бүрд сургаж, дадлагажуулах</p>	<p>Жилд 1 удаа</p>	 <p>Хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаанд гарын үсэг зуруулан, хөдөлмөр хамгааллын ажилтан болон Байгаль орчин хариуцсан ажилтан хянаж зааварчилгаа өгч дадлагажуулан ажиллаж байна</p>
<p>10</p>	<p>Аюултай хог хаягдал тээвэрлэх, устгах эрх бүхий байгууллагагай гэрээ байгуулан аюултай хог хаягдлыг тээвэрлүүлэх, устгуулах</p>	<p>Журамд заасан хугацаагаар</p>	 <p>Элемент ХХК тай гэрээ хийж, гэрээний дагуу тээвэрлэх, устгуулах арга хэмжээ авсан.</p>

ЦЭРГИЙН ГАВЬЯА ОДОНТ ГОВИЙН БҮСИЙН ТӨВ-ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ГУРВАНТЭС СУМ ДАХЬ ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ 67 ДУГААР АНГИ

ИЛТГЭХ ХУУДАС

"Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа "Сэкер ресурс Монголиа ХХК"-тай хамтран галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах тархалтын сургууль хийсэн тухай"

2025.09.26

Гурвантэс сум

Цэргийн гавьяа одонт Говийн бүсийн төв Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 67-р анги нь 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 11 цаг 00 минутад Гурвантэс сумын соёлын төвд "Сэкер ресурс Монголиа ХХК"-тай хамтран Байгууллагын галын аюулгүй байдлыг хангах, Гамшигт ослын үед авах арга хэмжээний талаархи сургалтыг Гал түймэрийн үлсын хяналтын байцаагч дэд хурандаа Б.Мөнхзул удирдан явуулж, Галын аюулгүй байдлын тухай, Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал /БНБД 21-01-02/ стандарт, техникийн нормативуудыг үндэслэн гал түймэр унтраах тархалтын сургуулийг зохион байгуулж ажиллав.

Тус компани нь Гурвантэс суманд авто замын засвар үйлчилгээний чиглэлээр нийт 11 туслан гүйцэтгэгч, компанитайгаа хамтран үйл ажиллагаа явуулж тэнхимийн болон практикийн дадлага сургуулийг 2 цагийн сургалтыг хамтран зохион байгуулсан.

Тэнхимийн сургалтаар ажилтан, алба хаагчдад галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөмж өгч мөн гамшигын болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт нормативын талаар сургалт зохион байгуулсан.

Дадлага сургалтаар нийт 11 байгууллагын 19 ажилтнаар Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх сургалт, болон анх шатны гал унтраах багаж зэвсэглэмжээр (гал унтраагуур)-аар урьдчилан бэлдсэн саванд гал асааж тус бүрээр гал унтраагуураар унтраах дадлага сургалтыг зохион байгуулсан.

ГТУА 67-р ангийн алба хаагчид тус объектын онцлог, өрөө тасалгаа барилгын хийц бүтэц, зам гарц, усан хангамжтай танилцаж, гал түймэр, осол аваарын үед түргэн шуурхай ажиллах арга тактикт суралцан мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэн ажилласан.

Сургалтад Гурвантэс суманд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 11 байгууллагын 19 хүн хамрагдаж гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион явуулан сургалт заавар зөвлөмж өгч тархалтын сургуулийн материалд тодотгол хийж материалжуулав.

ХЯНАСАН
ГАЛ ТҮЙМРИЙН ҮЛСЭН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ,
ДЭД ХУРАНДАА *[Signature]* Б.МӨНХЗУЛ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН
САЛААНЫ ЗАХИРАГЧ,
АХЛАХ ДЭСЛЭГЧ *[Signature]* Т.ОЧИРХҮҮ

ЗУРАГ



Зураг 47 Галын аюулгүй байдлын талаарх сургалт



Зураг 48 Гүйцэтгэгч нарт гарсан галын аюулгүй байдлын дүгнэлтийн хэсэг

5.16 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Баянхонгор аймгийн Шинэжинст суманд орших Хотгор чулуун нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурван Тэс сумын нутагт орших Нарийнсухайтын нүүрс тээврийн зам хүртэлх 288.45 км авто зам төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчээс боловсруулсан ажлын

даалгаврын дагуу төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг үнэлэх, байгаль орчны хяналт шинжилгээний хээрийн судалгааг хийж гүйцэтгэв. Хээрийн судалгааг 2025 оны 07 сарын 03-06-ны өдөр хийж гүйцэтгэсэн болно. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу орчны

хяналт шинжилгээний ажлын хүрээнд агаар, гүний ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг гэсэн чиглэлээр хяналт шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Байгаль орчны

хяналт, шинжилгээний ажлыг “Грийн солюшн консалтинг” ХХК-ийн судлаачдын баг ажилласан.

Хүснэгт 7 Дээж авсан цэгүүдийн цэгийн солбицол

	Сорьц авсан байршил		Цэгийн солбицол	
			Өргөрөг	Уртраг
Агаар	1	Зам 1	42° 58' 4.626" N	101° 18' 14.805" E
	2	Зам кемп 1	43° 6' 37.201" N	101° 17' 17.600" E
	3	Зам кемп 2, Бутлуур	43° 10' 5.408" N	101° 12' 37.565" E
	4	Зам кемп 3	43° 10' 47.475" N	101° 6' 5.599" E
	5	Зам кемп 4	43° 15' 43.285" N	101° 4' 19.452" E
	6	Зам кемп 5	43° 23' 38.558" N	100° 55' 37.494" E
	7	Замын хажууд хяналтын цэг	43° 27' 8.591" N	100° 39' 2.410" E
	8	Зам кемп 7	43° 27' 45.515" N	100° 29' 32.646" E
	9	Зам карьер	43° 51' 30.389" N	100° 4' 9.96" E
	10	Зам кемп 8	43° 46' 17.510" N	100° 6' 46.866" E
	11	Зам кемп 9	44° 0' 15.360" N	99° 54' 42.951" E
	12	Зам кемп 10	44° 10' 53.458" N	99° 40' 42.225" E
	13	Зам кемп 11	44° 20' 21.471" N	99° 25' 10.449" E
	14	Зам хяналт	44° 24' 53.788" N	99° 24' 6.063" E
	15	Иргэн Ж.Эрдэнэбаатар	44° 27' 29.641" N	99° 21' 4.574" E
Ус	1	Замын кемп-2 ААГ /Кемп-1/	43° 4' 41.176" N	101° 19' 56.672" E
	2	Худаг-2 /Кемп-2/	43° 10' 5.408" N	101° 12' 37.565" E
	3	Замын кемп К-2 /Кемп-3/	43° 28' 13.897" N	100° 28' 31.862" E
	4	Кемпийн ус 8 технологийн ус	43° 49' 34.141" N	100° 4' 49.984" E
	5	Хоолой-9 технологийн ус	43° 47' 27.72" N	100° 7' 22.90" E
	6	Нарандаац технологийн ус	43° 28' 13.897" N	100° 28' 31.862" E
	7	Гурвантэс сум	43° 13' 33" N	101° 02' 41" E
Хөрс	1	Road-1	42° 58' 4.58" N	101° 18' 14.06" E
	2	Auto parking	43° 06' 34.51" N	101° 17' 21.25" E
	3	Fuel tank	43° 06' 33.03" N	101° 17' 22.98" E
	4	Camp trash point	43° 10' 4.5" N	101° 12' 36.87" E
	5	Бутлуур үйлдвэр	43° 10' 46.99" N	101° 06' 5.43" E
	6	Cement plant	43° 15' 41.26" N	101° 04' 19.88" E
	7	Road workshop	43° 23' 37.21" N	100° 55' 38.33" E
	8	Road-2	43° 25' 29.83" N	100° 48' 24.16" E
	9	Road-3 camp	43° 27' 44.63" N	100° 29' 33.1" E
	10	Road-4 camp, карьер	43° 34' 5.14" N	100° 10' 34.34" E
	11	Road-5	43° 46' 14.64" N	100° 06' 48.59" E
	12	Road-6	43° 54' 5.76" N	100° 02' 58.15" E
	13	Road-7	44° 00' 20.38" N	99° 54' 38.45" E

	14	Road-8 camp	44° 06' 38.4" N	99° 44' 4.68" E
	15	Road-9 Карьер	44° 10' 52.86" N	99° 40' 42.0" E
	16	Road-10 camp-7	44° 20' 21.18" N	99° 25' 10.65" E
	Сорьц авсан байршил		Цэгийн солбицол	
			Өргөрөг	Уртраг
	17	Road-13 camp-2	44° 24' 53.17" N	99° 24' 6.15" E
	18	Road-14	44° 31' 59.62" N	99° 18' 37.65" E
	19	Карьер-6	43° 53' 52.53" N	100° 02' 48.89" E
	20	Road карьер-8	44° 06' 14.04" N	99° 44' 37.93" E
	21	Camp toilet	43° 27' 43.33" N	100° 29' 36.47" E
Ургамал	1	Мониторинг -1	42° 58' 5" N	101° 18' 15" E
	2	Мониторинг -2	43° 6' 40" N	101° 17' 25" E
	3	Мониторинг -3	43° 10' 7" N	101° 12' 36" E
	4	Мониторинг -4	43° 18' 44" N	101° 4' 25" E
	5	Мониторинг -5	43° 25' 34" N	100° 48' 28" E
	6	Мониторинг -7	43° 31' 43" N	100° 17' 1" E
	7	Мониторинг -8	43° 34' 5" N	100° 10' 35" E
	8	Мониторинг -9	43° 54' 8" N	100° 3' 2" E
	9	Мониторинг -10	44° 0' 21" N	99° 54' 38" E
	10	Мониторинг -11	44° 6' 39" N	99° 44' 6" E
	11	Мониторинг -12	44° 10' 53" N	99° 40' 44" E
	12	Мониторинг -13	44° 20' 23" N	99° 25' 11" E
	13	Мониторинг -14	44° 24' 54" N	99° 24' 6" E
	14	Кемп-1	43° 6' 38" N	101° 17' 21" E
	15	Кемп-2	43° 10' 6" N	101° 12' 37" E
	16	Кемп-3	43° 10' 48" N	101° 6' 6" E
	17	Кемп-4	43° 15' 43" N	101° 4' 19" E
	18	Кемп-5	43° 23' 37" N	100° 55' 39" E
	19	Кемп-6	43° 25' 34" N	100° 48' 28" E
	20	Кемп-7	43° 27' 46" N	100° 29' 36" E
	21	Кемп-8	43° 46' 17" N	100° 6' 48" E
	22	Кемп-9	44° 0' 21" N	99° 54' 38" E
	23	Кемп-10	44° 10' 54" N	99° 40' 42" E
	24	Кемп-11	44° 20' 23" N	99° 25' 11" E
	25	Карьер-1	43° 2' 35" N	101° 19' 52" E
	26	Карьер-2	43° 10' 49" N	101° 6' 7" E
	27	Карьер-3	43° 18' 43" N	101° 4' 24" E
	28	Карьер-4	43° 27' 6" N	100° 38' 32" E
	29	Карьер-5	43° 27' 1" N	100° 38' 2" E
	30	Карьер-6	43° 51' 30" N	100° 4' 10" E

5.17 Агаарын чанарын хяналт шинжилгээ

Зам 1, Зам кемп 1, Зам кемп 2, Бутлуур, Зам кемп 3, Зам кемп 4, Зам кемп 5, Замын хажууд хяналтын цэг, Зам кемп 7, Зам карьер, Зам кемп 8, Зам кемп 9, Зам кемп 10, Зам кемп 11, Зам хяналт, Иргэн Ж.Эрдэнэбаатар гэсэн арван таван цэгт агаарын хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), нийт тоос (нийт жинлэгдэгч бодис) болон дуу шуугиан үзүүлэлт тус бүрийг хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнгээр тодорхойлов.

Үүнд: Хүхэрлэг хий болон азотын давхар исэл: Хүхэрлэг хий болон азотын давхар ислийг тодорхойлохдоо химийн шинжилгээний аргачлалаар тодорхойлсон.

- **Хүхэрлэг хий:** Агаараас тетрахлормеркурат натрийн уусмал /ТХМ/-аар норгосон шингээгч гуурсанд 2 л/мин хурдтайгаар 20 минутын турш агаараас сорьц авч шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргад шингэсэн хүхэрлэг хийг лабораторийн нөхцөлд усан уусмалд шилжүүлж тэр уусмал дээрээ формальдегид, парарозаналины уусмал нэмэхэд үүссэн нэгдлийн өнгөний эрчимшлийг спектрофотометрээр хэмжин хүхэрлэг хийн

агууламжийг тодорхойлов.

- **Азотын давхар исэл:** Агаараас азотын давхар ислийг үл хатах мышьяклаг хүчлийн натрийн давс агуулсан кали иодын уусмалаар норгосон шингээгч гуурсаар 0.25 л/мин ын хурдтайгаар 20 минутын турш соруулан сорьц авч шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргаанд шингээж лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж үүссэн нитрит ион сульфанадины хүчилтэй харилцан үйлчилж диазонэгдлийг үүсгэх бөгөөд тэр нь нафтиламинтай урвалд орж азобудагч бодисыг уусмалын өнгөний эрчимшлээр азотын давхар ислийн хэмжээг тодорхойлов.

